



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2024 оны 12 дугаар сарын 13



**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв, эх үүсвэр /сая/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Зорилго: Зоонозын өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан улсын хэмжээнд зохион байгуулах, халдварын эрсдэлийг бууруулах, хүн амыг өвчлөл, эндэгдлээс урьдчилан сэргийлэх, тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлага, мэргэжил арга зүйгээр хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих							
Зорилт 1. Зоонозын өвчний байгаль дахь тархалт идэвхжилийг хянах, хүн амын дундах тархалт, эрсдэлийн түвшин тогтоох тандалт судалгааг өргөжүүлэх							
1.1	Баян-Өлгий, Увс аймагт тарваган тахал өвчний тандалт судалгааг хийж, голомтот нутгийн төлөв байдлыг тогтооно.	16,5сая ОХУ-ын хөтөлбөрийн санхүүжилт	Тандалт судалгааны тайлан	Хил орчмын 43 секторт хамрагдах 361000 га талбай, Увс аймгийн 144000 га талбай тандалт судалгаа хийсэн.	Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна.	Монгол улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын 1995 оны Эрүүл мэнд, анагаах ухааны салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр, 2021 оны Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Сибирь Алс Дорнодын тарваган тахлын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй байгуулсан хамтын ажиллагааны гэрээ, 2023 онд зохион байгуулагдсан Худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын засгийн газар хоорондын 25 дугаар хуралдааны тэмдэглэл, 2024 онд Монгол Улсын Эрүүл мэндийн сайд болон Оросын Холбооны Улсын Хүний эрүүл мэнд, хэрэглэгчийн эрхийг хамгаалах албатай байгуулсан хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж буй хөтөлбөрийн хүрээнд дараах олон улсын хамтарсан тандалт судалгааг хийж гүйцэтгэлээ. Үүнд: 1. ОХУ-ын Эрхүү хотын ТТЭСЭШХ, Горный Алтайн ТТЭСС, Баян-Өлгий аймгийн ЗӨСТ-ийн мэргэжилтнүүдтэй хамтран Монгол-Алтайн нурууны Сийлхэмийн бүлэг голомтод хамрагдах Баян-Өлгий аймгийн Улаанхус, Бугат, Ногооннуур (Цагааннуур тосгон) сумдын хил орчмын нутгуудад тарваган тахал өвчний байгалийн голомтын болон хүн амын дундах тандалт судалгааг хийж гүйцэтгэв. Уг тандалт судалгаагаар Баян-Өлгий аймгийн Улаанхус, Бугат, Ногооннуур (Цагааннуур тосгон) сумдын хил орчмын	100%

нутгаас нийт 45 мэрэгч (алтайн тарвага -19, урт сүүлт зурам-14, монгол огдой -12), мэрэгч амьтдын зэм үхдэл 119, гадны шимэгч 6, махчин шувууны гулгидас 1 зэрэг нийт 171 сорьц материал цуглуулж, камазад суурилсан авто лабораторит хурдавчилсан сорил, молекул биологийн шинжилгээний аргаар, Баян-Өлгий аймгийн ЗӨСТ-ийн лабораторит нян судлал болон биологийн шинжилгээний аргаар шинжилгээ хийсэн. Түргэвчилсэн ИХА сорилын дүн, молекул биологи, нян судлалын шинжилгээгээр 5 сорьц эерэг тодорхойлогдсоныг ЗӨСҮТ-ийн лавлагаа лабораторит баталгаажуулах, дүйн тодорхойлох, дэд зүйлийг тогтоох судалгаа, шинжилгээ хийсэн бөгөөд шинжилгээний дүнд тарваган тахлын нянгуудын 5 омог нь *Y.pestis.pestis* дэд зүйлийн үүсгэгч болох нь батлагдаж, тандалт судалгаагаар тарваган тахлын байгалийн голомт өндөр идэвхжилтэй байгааг тогтоож, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгууллаа.

Увс аймгийн Сагил, Бөхмөрөн сум орчмын ОХУ-тай хиллэх бүс нутагт тархсан мэрэгчдийн зүйлийн бүрдэл, нягтшил, тархалтыг тогтоох, бүс нутгийн голомтын төлөв байдал, эпизоотын идэвхжилийг орчны өөрчлөлттэй холбон судлах, хүн амд үзүүлэх эрсдэлт хүчин зүйлийг тогтоох, урьдчилах сэргийлэх сургалт сурталчилгаа хийх зорилгоор ОХУ-ын Эрхүү хот дахь Сибирь, Алс Дорнодын тарваган тахал эсэргүүцэн судлах эрдэм шинжилгээний хүрээлэн, ЗӨСҮТ, Увс аймгийн ЗӨСТ-ийн хамтарсан баг ажиллалаа. Шинжилгээнд нийт 22 секторын 198000 га талбай хамруулснаас 18 секторт тандалт, 4 секторт хайгуул, ажиглалт хийж, 4 зүйлийн 140 амьтан олборлосноос Монгол тарвага (*Marmota sibirica*)-40, Урт сүүлт зурам (*Spermophilus undulatus*)-67, Монгол огдой (*Ochotona pallasi*)-29, туулай (*Lepus tolai*)-3, хотьны үен (*Mustela erminea*)-1 зэрэг 140 амьтан, зэм үхдэл-31, бүүрэг-352, хачиг-1127, бөөс-79, нүхнээс 35 бүүрэг буюу 1558 гадны шимэгч нийт 1729 сорьцыг шинжилгээнд хамрууллаа. Шинжилгээнд хамрагдсан сорьцыг 2023 онд шинжилгээнд хамрагдсан сорьц, материалтай харьцуулахад амьтан 42%-иар их, гадны шимэгч 5,4 дахин их, сэг зэм 28.7%-иар бага илэрсэн байна. Тандалт судалгаагаар цуглуулсан сорьцод лабораторийн шинжилгээ хийхэд эерэг сорьц тодорхойлогдоогүй

						бөгөөд хамрагдсан секторуудад эрсдэл бага болохыг тодорхойллоо.	
1.2	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал. 5.1.2. Нийслэл, Төв, Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай аймгуудад хачгаар дамжих халдварын байгалийн голомт, хүн амын дундах тандалт судалгаа хийнэ.	10,6 Флоридагы н Их Сургууль	Тандалт судалгааны тайлан	Сонгинохайрхан дүүргийн нутагт 2015,2021 онд хийсэн тандалт судалгаагаар хачигт риккетсиозын үүсгэгч илэрч байсан. Төв аймагт 2022 онд хийсэн тандалтаар хачигт риккетсиоз болон анаплазмоз өвчний үүсгэгч илэрсэн.	Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна.	<p>Нийслэл, Төв, Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай аймгуудад хачгаар дамжих халдварын байгалийн голомт, хүн амын дундах тандалт судалгааг төвийн захирлын батлагдсан удирдамжийн дагуу 4 аймгийн нутаг дэвсгэрийг хамруулан 3 зүйлийн 1390 хачиг, эрсдэлт бүлгийн хүн амаас 22 ийлдэс цуглуулж, ийлдэс судлалын аргаар, цуглуулсан хачигт халдварын үүсгэгч тодорхойлох молекул биологийн шинжилгээг хийж гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай аймгийн зарим сумдын нутагт хачгаар дамжих халдварын байгалийн голомтын тандалт судалгааг тухайн аймгийн ЗӨСТ-ийн мэргэжилтнүүдтэй хамтран гүйцэтгэж <i>Dermacentor nuttalli</i> зүйлийн 660 хачиг, <i>H.asiaticum</i> зүйлийн 354 хачиг цуглуулсан. 2. Төв аймгийн Алтанбулаг, Баянчандмань, Жаргалант, Батсүмбэр сумын нутагт хачгаар дамжих халдварын байгалийн голомтын тандалт судалгааг Нийслэлийн ЗӨСТ-тэй хамтран гүйцэтгэж <i>Dermacentor nuttalli</i> зүйлийн 303 хачиг, <i>Ixodes persulcatus</i> зүйлийн 73 хачиг эрсдэлт бүлгийн хүн амаас 22 ийлдэс тус тус цуглуулж, үр дүнг тооцлоо. <p>Үр дүн: Батлагдсан удирдамж, аргачлалын дагуу тандалт судалгаагаар нийт 964 ширхэг <i>D.nuttalli</i> зүйлийн хачиг, <i>I.persulcatus</i> зүйлийн 73 хачиг, 354 ширхэг <i>H.asiaticum</i> зүйлийн хачиг тус тус түүвэрлэсэн нь бэлчээрийн хачиг буюу <i>Dermacentor nuttalli</i> зүйлийн хачгийн дундаж нягтшил нь 4.5 дарцаг/км байна. Хүн амын дундах хачигт халдварын тандалтын нийт 18 хүнээс цуглуулсан ийлдэст хачигт риккетсиоз, хачигт боррелиоз, хачигт энцефалит өвчний өвөрмөц эсрэгбие IgG тодорхойлох ФХУ шинжилгээ хийсэн бөгөөд хачигт риккетсиозын IgG-5, хачигт энцефалитийн IgG-1 эерэг тодорхойлогдсон. Цуглуулсан хачигт хийсэн ПГУ</p>	100%

						шинжилгээгээр Төв аймгийн Батсүмбэр сумаас цуглуулсан <i>Ixodes persulcatus</i> зүйлийн хачигнаас хачигт энцефалитийн үүсгэгчийг тодорхойлж, тухайн бүс нутагт хачигт энцефалитийн байгалийн голомттой болохыг тогтоолоо.	
1.3	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 5.1.2 Дорноговь аймгийн Даланжаргалан, Улаанбадрах сумын нутгаар хийх хачгаар дамжих халдварын байгалийн голомтын тандалт судалгаа хийнэ.	2,7 Флоридагын Их Сургууль	Тандалт судалгааны тайлан	Дорнод аймгийн Гурванзагал, Дашбалбар, Чулуунхороот, Баяндун, Баян-Уул аймгийн нутагт хачгаар дамжих халдварын тандалт судалгаагааг хийж, тандалт судалгааны тайлан бичигдсэн байна.	Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна.	Төвийн захирлын батлагдсан удирдамжийн дагуу 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 05 дугаар сарын 06-ны өдрийн хооронд Төв аймгийн Баян сум, Говьсүмбэр аймгийн Баянтал сум, Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутгаас 323 ширхэг <i>D.nuttalli</i> , Дорноговь аймгийн Сайншанд, Улаанбадрах сумдын нутгаас 250 ширхэг <i>H.asiaticum</i> зүйлийн хачгийг тус тус цуглуулж, хачигт халдварын үүсгэгч илрүүлэх молекул биологийн шинжилгээг хийж гүйцэтгэлээ. Үр дүн: Батлагдсан удирдамж, аргачлалын дагуу цуглуулсан хачигт хийсэн молекул биологийн шинжилгээ (PCR)-ний үр дүнгээр Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутгаас цуглуулсан <i>H.asiaticum</i> зүйлийн хачигнаас Крым конгийн цусархаг чичрэг өвчний үүсгэгч илрүүлж, тус бүс нутагт тархсан <i>H.asiaticum</i> зүйлийн хачиг нь Крым конгийн цусархаг чичрэг өвчний голомттой болохыг тогтоож, бусад ижил төрлийн судалгаа, тандалт судалгааны үр дүнтэй харьцуулж, хүний өвчлөл бүртгэгдэх эрсдэлтэй бөгөөд цаашдын нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, тандалт судалгааны чиглэлийг төлөвлөлөө.	100%
1.4	Дорноговь аймгийн Замын-үүд сумын нутагт хийгдэх тарваган тахлын хамтарсан тандалт судалгаа хийнэ.	4,7 БНХАУ-ын хамтын ажиллагааны гэрээний дагуу	Тандалт судалгааны тайлан	БНХАУ-тай хамтарсан тандалт судалгаагаар нийт 36000 га талбайд ажиллаж голомтын идэвхийг тогтоож, хамтарсан тандалтыг хийнэ.	Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна.	БНХАУ-ын Гаалийн ерөнхий газрын хорио цээрийн хяналтын газартай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу Хилийн боомт орчим тарваган тахлын байгалийн голомтын төлөв байдал, халдварын тархалт болон бор хархны хөдөлгөөн, хил дамнан тархах нөхцөл, зоонозын халдварын эрсдэлийг судлах, хүн амын дунд тандалт судалгаа хийж, эрсдэлт хүчин зүйлийг тогтоох зорилгоор Дорноговь аймгийн Замын-Үүд боомтод БНХАУ-ын Эрээн хотын гаалийн газар, Өмнөговь аймгийн ЗӨСТ-ийн мэргэжилтнүүдтэй хамтарсан тандалтын баг ажиллалаа. Монголын талд Иншаны голомтод хамрагдах Дорноговь аймгийн Замын-Үүд сумын төмөр замын Туннелийн хойд тал, (3714900842) Сэвхүүл тойром, (3714900844) Хогийн цэг, Төмөр замын гарам гэсэн 3 цэгт газар, БНХАУ-ын Эрээн хотын талд хоёр улсын хилийн зурвас бүс орчмын 2 цэгт газарт тандалт судалгааг хийж, гүйцэтгэлээ. Эрээн	100%

хотын талд Монгол улсын хилийн зурвас хэсэгт 2 цэгт газар ажиллаж, нийт 2 зүйлийн 13 мэрэгч, Монгол улсын талд 3 цэгт газрын 27000 га талбайд 400 хавхат зангат хоног ажиллуулж, 2 зүйлийн 16 жижиг мэрэгч, 2 зүйлийн 6 бүүрэг цуглуулан лабораторийн шинжилгээнд хамрууллаа.

Сүүлийн 3 жилд (2022-2024) зохион байгуулсан хамтарсан тандалт судалгаагаар бор хархны тархалт тогтоогдоогүй, бусад жижиг мэрэгчийн тархалт хумигдаж, хөдөлгөөний идэвх буурсан нь тус төвөөс сүүлийн 3 жил дараалан хийсэн мэрэгчгүйтгэлийн үйл ажиллагаатай холбоотой. Тус сумын нутагт хийгдсэн тарваган тахлын байгалийн голомт хяналтын шинжилгээ, судалгааны явцад хүн амын дундах мэдлэг, хандлага, дадлыг үнэлэхээр ЗӨСҮТ-ийн захирлын 2016 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/17 дугаар “Хүн амын дундах тандалтын журам”-ыг үндэслэн асуумж судалгааны аргаар нүүр тулсан ярилцлага хийж, мэдээ цуглуулан үнэлэхэд мэдлэг хандлагын хувьд тарваган тахал, хачигт халдвараар дамжих өвчний дамжуулагч амьтны талаарх мэдээлэл 18.3% буюу хангалтгүй, тарваган тахал, хачгаар дамжих халдварт өвчний дамжих замын талаарх мэдээлэл 17.4% буюу муу, тарваган тахал, хачигт халдвар өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг 37% буюу эрсдэлт бүлгийн хүн амын мэдлэг дутмаг байна. Иймд Дорноговь аймгийн Замын-Үүд сумын НЭ, ӨЭМТ-д мэдээлэл сурталчилгааг иргэдэд хийх талаар зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, эрсдэлт бүлгийн хүн амыг тарваган тахлын дархлаажуулалтад хамруулан, нийгмийн эрүүл мэндийн сургалт, сурталчилгааг идэвхжүүлэн ажиллалаа.

1.5	<p>“Алсын хараа- 2050” 2.2.1; МУЗГҮАХ 2.1.6; Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 5.2.2 Завхан аймгийн Тосонцэнгэл, Алдархаан, Их-Уул сумдын нутагт хачгийн байгалийн голомтын тандалт судалгаа, хачигт боррелиозын эмнэл зүйн үлдцийн судалгаа хийнэ.</p>	6,3 Флоридагын Их Сургууль Улсын төсөв	Тандалт судалгааны тайлан	2023 онд Завхан аймгийн Тосонцэнгэл суманд хийсэн тандалт судалгаагаар 6 эппиндорфийн 28 хачгийг сонгон зүйлийг тодорхойлж шинжилгээ хийснээс риккетсиозын DNA 53.57 хувьд илэрсэн.	Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна.	<p>Төвийн захирлын батлагдсан удирдамжийн дагуу Завхан аймгийн Тосонцэнгэл, Их-Уул суманд хачгийн байгалийн голомтын тандалт судалгаа, хачигт боррелиозоор өвчилж байсан иргэдийн дунд хачигт боррелиозын эмнэл зүйн үлдэцийг судлах зорилгоор тандалт судалгааг хийж гүйцэтгэлээ. Судалгаанд өмнө нь хачигт боррелиоз өвчнөөр батлагдсан болон тухайн үед сумын эрүүл мэндийн төвд хэвтэн эмчлүүлж байсан нийт 38 иргэнийг сонгон авч, асуумж судалгаанд хамруулан, бодит үзлэг хийж сорьц цуглуулж, батлагдсан аргачлалын дагуу байгалийн голомтыг хянах зорилгоор тус сумдын нутаг дэвсгэрээс нийт 101 хачиг цуглуулсан.</p> <p>Үр дүн: Судалгаанд хамрагдсан халдварлаж байсан түүхтэй болон эмнэлэгт эмчлүүлж байгаа иргэдээс авсан сорьцод хийсэн шинжилгээгээр 1 сорьцод хачигт боррелиозын эсрэг бие тодорхойлогдсон.</p> <p>Тандалт судалгааны явцад дээрх сумдын нутгаас цуглуулсан хачгийг ЗӨСҮТ-ийн шимэгч судлалын лабораторит морфологийн судалгаа хийж, <i>Dermacentor nuttalli</i> зүйлийн хачиг болохыг тодорхойлсон. Тандалт судалгааны хүрээнд цуглуулсан хачигт молекул биологийн шинжилгээ (PCR)-г хийхэд хачигт боррелиозын үүсгэгч тодорхойлогдоогүй.</p>	100%
1.6	<p>Архангай, Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудын Өгийнуур, Дойтын цагаан, Сангийн далай, Дөрөө, Эрхэл, Хунт зэрэг нууруудад шувууны томуугийн тандалт судалгаа хийнэ.</p>	Улсын төсөв	Тандалт судалгааны тайлан	Хэнтий, Сүхбаатар, Дорноговь, Төв аймгийн нутагт байршуулсан идлэг шонхрын 5000 үүрийг шалгаж нийт 650 орчим сорьц цуглуулсан.	Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна.	<p>Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говь-Сүмбэр, Төв аймгуудын Баянтөхөм, Далан, Балгасын улаан, Гашуун, Ногоон тойром, Сүм хөх бүрд, Тал гашуун, Шивээ-Овоо уурхайн Хаялга, Умбын цагаан, Бүс нууруудад шувууны томуу өвчний тандалт судалгааг хийж гүйцэтгэлээ. Шувууны томуугийн өвчлөл бүртгэгдэх эрсдэл нь нүүдлийн шувуудаас гадна тэжээвэр шувууны аж ахуй, төв суурин газраас алслах зай, айл, жуулчны баазын тоо, малын тоо зэргээс хамаарах тул нуур тус бүрээр мэдээлэл цуглуулж, эрсдэлийг тогтоосон.</p> <p>Уг тандалт судалгаагаар нийт 35 цэгт газраас 7 зүйлийн шувууны 130 сангас цуглуулж, сорьцыг УМЭАЦТЛ-ын Вирус судлалын лабораторит бодит цагийн УТ-ПГУ-аар шинжлэхэд шувууны томуугийн А хүрээний М уураг тодорхойлогч генийн өвөрмөц хэсэг тодорхойлогдоогүй буюу тухайн хугацаанд шувууны томуу өвчний эрсдэлгүй болохыг тодорхойллоо.</p> <p>Судалгааны дүгнэлтээр төвийн болон говийн бүсийн нууруудад цаашид зөвхөн хаврын улиралд шувууны тандалт судалгаа хийвэл илүү тохиромжтой байна.</p>	100%

1.7	<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 5.1.1</p> <p>Тарваган тахлын байгалийн голомтын эпизоотын онцгой идэвхжилтэй Монгол Алтайн бүс нутагт мэрэгчгүйгэтгэл хийж эрсдэлийг бууруулна.</p>	11 БНХАУ-ын хамтын ажиллагааны гэрээний дагуу	Мэрэгчгүйгтгэл, шимэгчгүйгтгэл хийсэн талбай, Буурсан эрсдэлийн хувь	Баян-Өлгий аймгийн Улаанхус, Ногооннуур сумдын суурьшлийн бүсэд мэрэгчгүйгтгэл, шимэгчгүйгтгэл хийсэн.	Төлөвлөсөн бүс нутагт мэрэгчгүйгтгэл, шимэгчгүйгтгэл хийж, үр дүнг хянасан байна.	<p>Тарваган тахал өвчний байгалийн голомтын эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хүрээнд эрсдэл бүхий 2 аймагт орон нутгийн төсвөөр 30000 га талбайд мэрэгчгүйгтгэл, шимэгчгүйгтгэлийн ажлыг зохион байгууллаа. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Баян-Өлгий аймгийн Улаанхус, Ногооннуур сумын голомтот нутгийн 12000 га талбайд мэрэгчгүйгтгэл, шимэгчгүйгтгэлийн ажил хийж 80ш алтайн тарвага агнан устгаж, 800ш огдой, зурам зэрэг амьтны нүхний амсарт мэрэгч устгах 0,007% бромадиолонтой хорыг байршуулан, ОХУ-д үйлдвэрлэгдсэн 96кг шимэгчийн хороор 2400 тарваганы нүхний амсарт шимэгчгүйгтгэл хийж гүйцэтгэлээ. 2. Говь-Алтай аймгийн Цээл сумын Хүн толгой, Бугат сумын Ар цагаан сайрын аман дахь 18000 га талбайд “фенаксин” хуурай 120 кг, шингэн хэлбэрээр 2000 литрийг зарцуулж, 5175 мэрэгчийн нүх түүний амсарт хороор шимэгчгүйгтгэх үйл ажиллагааг тус тус зохион байгууллаа. 	100%
1.8	<p>Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутаг “Бичигт”-ийн боомт орчим тарваган тахал, хам тохиолдох халдварт өвчний тандалт судалгаа хийнэ.</p>	Улсын төсөв	Тандалт судалгааны тайлан	2019 оны тандалтаар 3 зүйлийн мэрэгч, туулай хэлбэртэн олзворлосоноос бор хархны тархалт орон байранд ихэссэн болон хээрийн талбайд тархсан байсан.	Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна.	<p>Төвийн захирлын батлагдсан удирдамжийн дагуу Сүхбаатар аймгийн “Бичигт”-ийн боомт орчим зоонозын халдварт өвчний эрсдэлт хүчин зүйлийг тогтоох зорилгоор тандалт судалгааг хийж, 5 сектор 45000 га талбайг хамруулсан лабораторийн шинжилгээнд 5 зүйлийн мэрэгч амьтны тархалт, тоо толгойг тогтоож, мэрэгчийн 88 сорьц, хүн амаас тарваган тахал өвчний мэдлэг, дадал, хандлага, эрсдэлийг тогтоох зорилгоор нийт 63 асуумж судалгаа авлаа. Уг тандалт судалгаагаар:</p> <ol style="list-style-type: none"> 1. Цуглуулсан сорьцод хийсэн лабораторийн шинжилгээгээр пастерелёз, хуурмаг ям, ям, листерёз, хулгана тахал, хуурмаг сүрьеэ, эрлихиоз, бартонелла зэрэг хам тохиолдох халдваруудын үүсгэгчийн ДНХ илрүүлэх энгийн молекул биологийн шинжилгээ хийхэд сөрөг тодорхойлогдож, зоонозын халдварын эрсдэлгүй байгааг тогтоолоо. 2. Хүн амын дундах мэдлэг хандлагыг үнэлэх асуумжаар 18.7% буюу хангалтгүй, тарваган тахал өвчин дамжих замын талаарх мэдээлэл 17.7% буюу муу, тарваган тахал өвчнөөс 	100%

						урьдчилан сэргийлэх мэдлэг 26% буюу дутмаг байна. Цаашид тухайн орон нутгийн хүн амд зоонозын халдвараас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг тогтмол түгээж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөлөө.	
1.9	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 5.2.3 Шувууны томуу өвчний байгалийн голомтын эрсдэлийн мэдээллийн сан үүсгэнэ.	-	Хүргүүлсэн мэдээний тоо	Дэлхий дахинд болон манай оронд бүртгэгдсэн шувууны томуугийн 14 хоног тутмын мэдээг бэлтгэн цахим хуудсанд байршуулан иргэд олон нийт болон салбар хоорондын байгууллагуудад мэдээлэл хүргэсэн байна.	Шувууны томуу өвчний байгалийн голомтын тандалт судалгааны тоо мэдээг нэгтгэж холбогдох байгууллагад мэдээлсэн байна.	Мэдээллийн санд нүүдлийн шувууны ажиглалт, тооллогын мэдээг цахим аппликэйшн ашиглан оруулж, дүн шинжилгээ хийж байна. Уг мэдээллийн санг тухайн жилд шинээр хэрэглээнд нэвтрүүлснээр 5 аймгийн ЗӨСТ-ийн мэдээлэл нэгтгэгдсэн. 2024 оны жилийн эцсийн байдлаар 12 аймгийн 82 том, жижиг нууранд нүүдлийн шувуудын тооллого хийсэн ба үүнээс 6 аймгийн 45 нуурын орчны үнэлгээг мэдээллийн санд оруулан ашиглаж байна. Мэдээллийн сан үүсгэх, хөгжүүлэх ажлын хүрээнд амьтан судлагч, шимэгч судлагч, тархвар судлагч зэрэг 6 мэргэжилтнийг газарзүйн мэдээллийн системийн сургалтад хамруулж сертификат олгон уг чиглэлээр ажиллаж буй хүний нөөцийг чадавхжууллаа. Шувууны томуу өвчний байгалийн голомтын мэдээллийн сан үүсгэснээрээ болзошгүй өвчлөл бүртгэгдсэн үед тухайн сангийн мэдээлэлд үндэслэж, хариу арга хэмжээг төлөвлөх боломжтой. Цаашид төвийн болон говийн бүсийн нууруудад хаврын улиралд шувууны тандалт судалгааг хийх нь илүү тохиромжтой байна. Шувууны томуугийн өвчлөлийн эрсдэл нь нүүдлийн шувуудаас гадна тэжээвэр шувууны аж ахуй, төв суурин газраас алслах зай, айл, жуулчны баазын тоо, малын тоо зэргээс хамаарах тул нуур тус бүрээр мэдээлэл цуглуулж эрсдэлийг тогтоосон.	90%
1.10	Мал эмнэлгийн ерөнхий газартай хамтран малын эмч нар дунд бруцеллёз өвчний тархалт болон ажлын байрны эрсдэлийг үнэлнэ.	Улсын төсөв Төсөл хөтөлбөр	Тандалт судалгааны тайлан	Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв 2018 онд нийслэлийн 4 дүүрэг, Төв аймгийн хүн амын дунд бруцеллёз өвчний тандалт судалгааг хийсэн.	Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна	МЭЭГ-ын харьяа Нийслэлийн мал эмнэлгийн газартай хамтран малын эмч нарын дунд мэргэжлээс шалтгаалах бруцеллёз өвчний эрсдэлийг үнэлж, халдваржилтыг тогтоох зорилгоор Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг төр, хувийн хэвшлийн мал эмнэлгийн 10 гаруй байгууллагын 53 мэргэжилтнийг тандалт судалгаанд хамруулж, сорьц цуглуулан, асуумж судалгаа авсан. Уг судалгаагаар: 1. Судалгаанд хамрагдсан малын эмч нарын 13.5% нь 1 жил, 9.6% нь 1-5 жил, 21% нь 5-10 хүртэлх жил, 42% нь 10-аас дээш жил тус салбарт ажилласан байна. Бруцеллёзын халдвараас сэргийлэх мэдлэг, хандлага 100% байсан хэдий ч нийт сорьцод хийсэн	100%

						<p>лабораторийн шинжилгээгээр 9.4% (5 хүн) нь бруцеллөз өвчний халдвартай байгааг (<i>B.Abortus</i>) тогтоосон.</p> <p>2. Судалгааны үр дүнд малын эмч нарын мэдлэг, хандлага, өндөр байсан ч мэргэжлийн үйл ажиллагааны (өвчтэй мал, амьтантай харьцах, бруцеллөзын амьд вакцин хийх үед тариурын зүүнд хатгуулах г.м) явцдаа халдварт өртөх эрсдэлтэйг харуулж байна.</p> <p>Иймд аливаа эрсдэл үүссэн үед мэргэжлийн байгууллагад хандаж зөвлөгөө, үзлэг, шинжилгээнд хамрагдах шаардлагатай байна. Цаашид тандалт судалгааг орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг мал эмнэлгийн байгууллагын мэргэжилтнүүдэд үе шаттай зохион байгуулж ажиллахаар төлөвлөсөн.</p>	
1.11	Архангай аймгийн Өлзийт сум, Булган аймгийн Сайхан сум, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум зэрэг Орхон голын ай сав газруудаар шувууны томуу болон шумуулаар дамжих халдварын тандалт судалгаа хийнэ.	Улсын төсөв	Тандалт судалгааны тайлан	<p>2014 онд Сэлэнгэ аймагт хийсэн тандалтаар Баруун Нилийн чичрэг, Япон энцефалит, 2015 онд Дорнод аймагт хийсэн тандалтаар Дэнге чичрэг, Баруун Нилийн чичрэг өвчнүүд лабораторийн шинжилгээгээр эерэг гарч байсан.</p>	Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна.	<p>Тандалт судалгааны хүрээнд Орхон голын ай, сав газруудаар шумуулын зүйлийн бүрдэл, тархалт, халдварын эрсдэлийг тогтоох, шумуулаар дамжих халдварын хүн амын дундах тархалт, халдварт өртөх эрсдэл, мэдлэг, дадлыг үнэлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх талаар орон нутгийн ард иргэдэд 12 удаагийн яриа, 80 ширхэг зурагт хуудас түгээх, сургалт, сурталчилгаа хийх үйл ажиллагааг 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс 26-ны өдрийг хүртэлх хугацаанд Архангай аймгийн Өгийнуур, Өлзийт, Булган аймгийн Сайхан, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумдын нутагт хийж гүйцэтгэсэн.</p> <p>Үр дүн: Тандалт судалгаагаар тухайн бүс нутагт амьдарч буй нийт 84 хүнээс асуумж судалгаа авч, 29 хүнээс цусны ийлдсийг шинжлэхэд шумуулаар дамжих халдваруудын (<i>денгийн халуурал, баруун нилийн чичрэг, шар чичрэг</i>) эсрэгбие тодорхойлогдоогүй.</p> <p>Уг судалгааны хүрээнд 8 цэгт газраас 1274 шумуул цуглуулж, тэдгээрийн төрөл зүйлийг тогтоох, шумуулаар дамжих халдварын үүсгэгч илрүүлэх молекул биологийн шинжилгээг гүйцэтгэсэн. Лабораторийн шинжилгээнд <i>culex</i> төрлийн 100 шумуулд бүтэн геномын дараалал тогтоох NGS шинжилгээ хийж, тухайн бүс нутагт <i>Culex pipens</i> зүйлийн шумуулын тархалттай байгааг тодорхойлсон. Шумуулаар дамжих халдварын үүсгэгч илрүүлэх молекул биологийн шинжилгээний үр дүнгээр шумуулаар дамжих халдварын үүсгэгч тодорхойлогдоогүй.</p>	100%

1.12	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 5.2.5 Булган, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймгийн малчид, малын эмч, хүүхдүүдийн дунд анзаарагддаггүй өвчний тандалт судалгааг хийнэ.	12 Төсөл хөтөлбөр	Тандалт судалгааны тайлан	Улсын хэмжээнд 2012-2016 онд хийгдсэн тандалт судалгаагаар криптоспорици оз өвчний үүсгэгчийн ген тодорхойлогдож, манай орны хүн, мал амьтны дунд уг өвчний халдваржилт байгаа болохыг тогтоосон.	Тандалт судалгааг хийж, тайлан бичиж, зөвлөмж хүргүүлсэн байна.	2021 оны Дэлхийн Эрүүл Мэндийн Ассамблейн WNA7(33) чуулганаар Анзаарагддаггүй өвчнүүдийн шинэ замын зураглалыг баталсан бөгөөд бэтэг, цистецеркоз, шистозомоз, токсолазмоз, фасцелиоз, хөрсөөр болон хүнсээр дамждаг гельментийн өвчнүүдийг 2030 он гэхэд бүрэн хяналтад оруулахаар уриалсан бөгөөд уг уриалгыг Эрүүл Мэндийн Яам хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд удирдамжийн дагуу томилогдсон тандалт судалгааны баг УМЭАЦТЛ-ын мэргэжилтнүүдтэй хамтран 3 аймгийн 5 суманд үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.	90%
1.13	Хүнсээр дамждаг гельминтийн судалгаа	Улсын төсөв	Тандалт судалгааны тайлан	АШУУИС-ийн судлаачийн хийсэн судалгааны дүнгээр гельминтийн халдварын эрсдэл өндөр байсан.	Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна.	Хүнсээр дамждаг, гельминтээр үүсгэгдэх өвчний хяналтыг сайжруулах, эрсдэлийг үнэлэх зорилгоор Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг хүнсний зах, худалдааны төвүүдэд тандалт судалгааг хийхээр Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторитой (ХАБҮЛЛ) хамтарсан судалгааны баг бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Бэлтгэл ажлын хүрээнд: 1. ХАБҮЛЛ-той хамтран ажиллах санамж бичгийн төсөл боловсруулж, баталсан бөгөөд батлагдсан санамж бичгийн хүрээнд төвийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тандалт судалгаагааны ажлыг тусгаж, хэрэгжүүлэхээр төлөвлөж, ажиллах баг, бүрэлдэхүүнийг томилох зэрэг үйл ажиллагааг гүйцэтгээд байна. Тухайн үйл ажиллагааны зардал хамтрагч байгууллага болон тус төвийн 2024 оны төсөвт тусгагдаагүй тул хамтарсан төсөл боловсруулж, эрүүл мэндийг дэмжих сан болон холбогдох донор байгууллагуудад хүргүүлэн танилцуулж, хариуг хүлээж байна.	65%

1.14	Бэтгийн хорхойны жинхэнэ эзэн нохойн хоолны халдварыг тогтоох тандалт судалгаа	Улсын төсөв	Тандалт судалгааны тайлан	2018 онд Баянгол, Хан-Уул дүүргийн хүн амын дунд хийсэн судалгааны дүнгээр мэдлэг хандлага сул эрсдэл өндөр байсан.	Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна.	Тус төвөөс гельминтээр үүсгэгддэг халдваруудыг тандах, бүртгэх, мэдээллүүдийг тодорхойлох ажлыг улсын хэмжээнд зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд нийт 8 аймгийн ЗӨСТ-өөс ирүүлсэн чоно, үнэг, хярс, ондатрын 15 сорьцод гельминтийн шинжилгээг хийж, гүйцэтгэсэн. Үүнд: 1. Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумаас олзворлосон чононоос бие гүйцсэн бэтгийн хорхой цуглуулж, молекул биологийн шинжилгээ (PCR) хийж <i>E.canadensis</i> төрлийн хорхой болохыг тогтоосон. 2. Ховд аймгийн Чандмань сумаас олзворлосон ондатраас (заарт харх) бие гүйцсэн бэтгийн хорхой цуглуулж, молекул биологийн шинжилгээ (PCR) хийж <i>E.canadensis</i> төрлийн хорхой болохыг тогтоосон. Энэ нь ондатраас бэтэг өвчний үүсгэгч илрүүлсэн анхны тохиолдол юм. 3. Увс аймгийн Улаангом сумаас олзворлосон хярснаас бие гүйцсэн бэтгийн хорхой цуглуулж, молекул биологийн шинжилгээ (PCR) хийж <i>E.multilocularis</i> төрлийн хорхой болохыг тогтоосон. Энэ нь зэрлэг амьтдын дундаас ялангуяа хярснаас бэтэг өвчний үүсгэгч <i>E.multilocularis</i> төрлийн хорхой олдсон анхны тохиолдол юм.	100%
Зорилт 2. Зоонозын өвчинтэй тэмцэх, сэргийлэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, урьдчилан сэргийлэх хүн амд эрүүл мэндийн боловсорол олгох, дэмжих							
2.1	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/464 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 5.1.4 Зоонозын өвчний оношилгоо, эмчилгээний зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулна.	11 сая Төсөл хөтөлбөр	Батлагдсан зааврын тоо	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/160 дугаар тушаал хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.	Зоонозын 24 өвчний тандалт, оношилгоо, эмчилгээний зааврыг шинээр батлуулан мөрдөж ажилласан байна.	Зоонозын өвчний оношилгоо, эмчилгээний 14 өвчний зааврын төслийг боловсруулж мэргэжлийн зөвлөлд танилцуулж санал авсан. Зоонозын 15 өвчний тандалт, оношилгоо, эмчилгээний зааврыг шинэчлэн боловсруулж, төвийн Мэргэжлийн зөвлөлд танилцуулж санал авсан. Саналын дагуу засваруудыг хийж, төвийн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, ЭМЯ-д тушаалын төслийн хамт саналаа хүргүүлсэн.	85%

2.2	Аймаг, нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвөөс тайлан авах болон хяналт үнэлгээний журмыг шинэчлэн боловсруулан батлуулна.	-	Шинэчлэн батлагдсан журам	Төвийн захирлын 2017 оны тушаал А/79 төгөлдөр мөрдөгдөж байна.	2024 онд ЗӨСТ-үүдээс жилийн эцсийн тайланг шинэчлэн батлагдсан журмын дагуу авна.	Аймаг, нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвөөс тайлан авч, нэгтгэн, хяналт үнэлгээ хийх журмыг холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг үндэслэн шинэчлэн боловсруулж, 2024 оны Удирдлагын зөвлөлийн №3 дугаар хурлаар хэлэлцүүлэн Төвийн захирлын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/18 дугаар тушаалаар батлуулан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тус журамд Нийслэл, аймгийн ЗӨСТ-үүдийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг үнэлэх үүрэг бүхий ажил дүгнэх байнгын комиссын бүрэлдэхүүн, төвүүдийн жилийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнд хяналт-үнэлгээ хийх журам, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн гүйцэтгэл, гүйцэтгэлийн хяналт шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд, тайлан бичих дараалал, тайлагнах хугацаа зэргийг тусгасан нь салбарын хэмжээнд мөрдөж буй бодлого үйл ажиллагаатай уялдаж байна.	100%
2.3	Төвийн дунд хугацааны 2024-2026 оны стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулна.	-	Батлагдсан стратеги төлөвлөгөө	Төслийг боловсруулсан.	Төвийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө ө батлагдан хэрэгжиж эхэлсэн байна.	Эрүүл мэндийн сайд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр “Зоонозын өвчин судлалын үндэсний төв”-ийн 2024-2027 оны стратеги төлөвлөгөө баталсан. Уг батлагдсан төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн Газар, Эрүүл мэндийн яамны салбарын бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Стратеги төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилт 100%-ийн биелэлттэй байна.	100%
2.4	Төвийн цахим хуудас, нийгмийн сүлжээг зохицуулах журам боловсруулан батлуулна.	Улсын төсөв	Батлагдсан журам	-	Төвийн цахим хуудас, нийгмийн сүлжээг зохицуулах журам батлуулна.	Төвийн цахим хуудас, нийгмийн сүлжээг хөтлөх болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай харилцах үйл ажиллагааг зохицуулах журмыг боловсруулан 2024 оны Удирдлагын зөвлөлийн №4 дүгээр хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, төвийн захирлын 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А/20 дугаар тушаалаар батлан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	100%
2.5	МУХТЖҮЧ 2.2.2; ЗГҮАХ 1.1.3.3; Алсын хараа 2050 2.2.3, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 8.2.2 Зорилтот бүлгийн иргэдэд зоонозын	Улсын төсөв	Цахимаар хүргэсэн мэдээлэл сургалт сурталчилга аны	2023 онд зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цахим хуудас 235 мэдээ	Зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл, сургалт, сурталчилга ааг	Иргэд, олон нийтэд зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээлэл хүргэх үйл ажиллагааг дараах байдлаар зохион байгууллаа. Танхимын сургалт мэдээлэл: 1. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Бичигт боомтод ажилладаг ЭАХХУ-ын байцаагч нар болон боомтын 20 ажилтан, албан хаагчдад тарваган тахал өвчний тархвар судлал, хариу	100%

	<p>өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулна.</p>		<p>хандалтын тоо</p>	<p>нийтэлсэн. Нийт хандалт 228947 байна. Фэйсбүүк хуудас 482 мэдээ нийтэлсэн. Нийт хандалт 453761 байна.</p>	<p>цахимаар зохион байгуулна.</p>	<p>арга хэмжээний талаар сургалт зохион байгуулав.</p> <ol style="list-style-type: none"> Дорноговь аймгийн Замын-Үүд суманд хийгдсэн тандалт судалгаагаар тус суманд оршин суудаг 80 гаруй иргэд, Баян-өлгий аймагт хийгдэж буй тандалт судалгааны хүрээнд 100 гаруй өрхөд тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл хүргэлээ. Архангай, Булган, Сэлэнгэ аймгийн зарим сумдад хийгдсэн тандалт судалгаагаар 85 иргэнд хачигт халдвар болон шумуулаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зурагт хуудас тарааж мэдээлэл хүргэлээ. Тарваган тахал өвчний тархвар судлал, хариу арга хэмжээний талаар Нийслэлийн яаралтай тусламжийн 103 төвийн 150 гаруй эмч мэргэжилтнүүдэд танхимын сургалт зохион байгуулсан. БНӨС улсад НҮБ-ын мандаттай UNMISS ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн Монгол Улсын Зэвсэгт хүчний 013, 150 дугаар ангийн 674 энхийг сахиулагч нарт 4 удаа Хумхаа өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээллийг хүргэж, сургалт зохион байгуулсан. <p>Телевизийн ярилцлага:</p> <ol style="list-style-type: none"> ТМ, Eagle, UBS, NTV, C1, Монгол, TV25, Tenger Tv, МҮОНТВ-д галзуу, хачгаар дамжих халдвар, боом, тарваган тахал өвчний нөхцөл байдлын болон урьдчилан сэргийлэх 19 удаагийн ярилцлага өгсөн байна. Экологийн цагдаагийн алба, ЗОС ФИЛЬМ МЕДИА ГРУПП ХХК-тай хамтран Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар видео контент 3-ийг бэлтгэн нийтэлсэн. <p>Радио ярилцлага:</p> <ol style="list-style-type: none"> МҮОНР-ийн эрүүл мэндийн нэвтрүүлэг, Баян-өлгий аймгийн радио телевизэд тус төвийн эмч, мэргэжилтнүүд оролцож малчид, ард иргэдэд 3 удаагийн зоонозын өвчний мэдээлэл, зөвлөгөө, сэрэмжлүүлэг өгсөн байна. <p>Цахим сүлжээ:</p> <ol style="list-style-type: none"> Цахим хуудас: 203 мэдээ нийтэлсэн бөгөөд хандалтын тоо 186670 байна. 	
--	---	--	----------------------	--	-----------------------------------	--	--

						<p>2. Олон нийтийн сүлжээ: 418 мэдээ нийтэлсэн бөгөөд хандалтын тоо 298181 байна. Тарваган тахал, галзуу, боом, анзаарагддаггүй халдварт өвчин, бэтэг өвчнүүдээс сэргийлэх, эрсдэлд өртсөн үед авах арга хэмжээ болон гамшгийн үеийн буюу үерийн үед зоонозын халдвараас сэргийлэх мэдээ мэдээллийг нийгмийн сүлжээнд байршуулан, хүргэж байна.</p> <p>3. Төвийн фэйсбүүк хуудасны чатбот 24/7 горимоор ажиллан 84 иргэнд мэдээлэл хүргэсэн байна.</p> <p>Мэдээллийн сайт:</p> <p>1. isee.mn, gogo.mn, mnb.mn, itoim.mn, news.mn, eagle.mn, news.mn, lkon.mn, Zugii.mn, Tsahiur.mn, Zarig.mn, Өдрийн сонин зэрэг мэдээллийн сайтуудад нийт 32 удаагийн ярилцлага, мэдээлэл өгсөн.</p> <p>Шинээр боловсруулсан инфографик, постер:</p> <p>1. Анзаарагддаггүй халдвар-26, Зоонозын халдварт өвчний тухай-1, Денги-1, Боом-2, Бруцеллээ-1, Хачгаар дамжих халдвар-3, Халдваргүйжүүлэлт-6, боом өвчний тухай видео-1, постер-1 Галзуу-1, Сармагчингийн цэцэг-1 удаагийн контент боловсруулан цахим мэдээллийн хэрэгслээр дамжуулан ард иргэдэд мэдээлэл хүргэн ажилласан.</p>	
2.6	Зоонозын өвчинтэй тэмцэх дэлхийн өдрүүдийг угтсан ажлыг зохион байгуулна.	Улсын төсөв	Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Төлөвлөгөөт ажлыг зохион байгуулсан.	Төлөвлөгөөт сургалт, сурталчилгаа бүрэн хийгдсэн байна.	<p>Зоонозын өвчинтэй тэмцэх дэлхийн өдрүүдийг угтан зоонозын халдварт өвчнүүдийн талаарх мэдээ, мэдээлэл хүргэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажиллалаа.</p> <p>Үүнд:</p> <p>1. ДЭМБ-аас гаргасан 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр “Нэгд, Хий, Устга” уриан дор анзаарагддаггүй өвчнүүдийн дэлхийн өдрийг зохион байгууллаа.</p> <ul style="list-style-type: none"> - МҮОНП-аар дэлхий дахинд болон Монгол улс дахь хүн амд анзаарагддаггүй өвчнүүдийн өнөөгийн нөхцөл байдал, сэргийлэлт, хариу арга хэмжээний талаарх мэдээлэл хүргэсэн. Мөн үүнтэй холбоотой ярилцлага мэдээллийг www.mnb.mn, www.egel.mn мэдээллийн сайтуудад нийтлэв. - Анзаарагддаггүй өвчнүүдийн мэдээлэл бүхий 24 инфографик шинээр боловсруулан, нийтэлж иргэд, олон нийтийг мэдээллээр хангалаа. 	100%

						<p>2. Хумхаа өвчинтэй тэмцэх дэлхийн өдөр: 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр “Эрх тэгш, шударга нийгмийг бүтээхийн төлөө хумхаа өвчний эсрэг тэмцлийг эрчимжүүлье” уриан дор хумхаа өвчинтэй тэмцэх дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүллээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн яам болон төвийн цахим хуудсаар хумхаа өвчинтэй тэмцэх өдөр болон уг өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээллийг хүргэсэн. - “Хумхаа өвчний хяналт, сэргийлэлт” сэдвээр ЭМЯ-ны хэвлэл мэдээллийн төвөөс лайв, News.mn мэдээллийн сайт, МҮОНП-аар иргэд, олон нийтэд хумхаа өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө мэдээлэл хүргэсэн. <p>Галзуу өвчинтэй тэмцэх дэлхийн өдөр: 2024 оны 09 дүгээр сарын 28-нд Галзуу өвчинтэй тэмцэх Дэлхийн өдрийг тохиолдуулан “Бид галзуу өвчнөөс 100% урьдчилан сэргийлж чадна” уриатайгаар видео контент, урьдчилан сэргийлэх мэдээлэл бүхий постерыг төвийн албан ёсны цахим хуудсаар нийтэлж, иргэд олон нийтийг мэдээ, мэдээллээр хангалаа.</p>	
<i>Зорилт 3. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах</i>							
3.1	Зоонозын өвчний тохиолдол бүртгэгдсэн үед тухай бүр эрсдэлийн үнэлгээ хийнэ.	-	Эрсдэлийн үнэлгээний тоо	2023 онд зоонозын өвчний сэжигтэй 17 тохиолдолд эрсдэлийн үнэлгээ хийж, эргэн мэдээлэл, зөвлөмжөөр ханган ажилласан.	Эрсдэлийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг холбогдох газарт хүргүүлж, голомтыг цомтгох арга хэмжээг авсан байна.	Улсын хэмжээнд 2024 онд зоонозын халдварын хүний өвчний сэжигтэй 936 дуудлагыг хүлээн авч хариу арга хэмжээ авч, эрүүл мэндийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг зохион байгуулан ажиллалаа. Зоонозын халдварт өвчний бүртгэгдсэн сэжигтэй тохиолдлын дуудлагаас галзуугийн сэжигтэй мал, амьтанд уруулж, ноцуулсан тохиолдол 433 (46.3%), хачигт риккетсиоз 364 (38.9%), хачигт энцефалит 82 (8.8%), бэтэг 17 (1.8%), хачигт боррелиоз 13 (1.4%), тарваган тахал 9 (1.0%), хумхаа 9 (1.0%), боом 5 (0.5%), бруцеллэз 3 (0.3%), токсоплазмоз 1 (0.1%) өвчний тохиолдол тус тус байна. Нийт дуудлагаас хачгаар дамжих халдвар 49.8 хувийг, галзуугийн эрсдэлд өртсөн тохиолдол 46.3 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байна. 2024 онд токсоплазмоз өвчний тохиолдол шинээр нэмэгдсэн. - Үүнээс зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй 936 дуудлага бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар өссөн, сүүлийн 5 жилийн дундажаас 12.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	100%

- Дуудлага хяналтын жижүүрийн 24 цагийн 70282853 дугаарт 4240 дуудлага хүлээн авч иргэд болон холбогдох байгууллагуудад цаг алдалгүй зөвлөмж, зөвлөгөө, мэдээлэл өгч, голомтод хариу арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Утсаар өгсөн зөвлөмжийн тоо өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар өссөн байна.

Бүртгэгдсэн зоонозын халдварт өвчний тохиолдол, дэгдэлтийн үед Монгол улсын Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалаар батлагдсан “Болзошгүй гамшиг осол, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй үйл явдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ын дагуу 5 удаагийн эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ хийсэн. Эрсдэлийн үнэлгээний түвшинд тохирсон хариу арга хэмжээг холбогдох хууль, эрх зүйн хүрээнд нийцүүлэн зохион байгуулж, зөвлөмж боловсруулан хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.

Үүнд:

1. Дундговь аймгийн Хулд суманд бүртгэгдсэн боомын малын өвчлөлд эрсдэлийг түргэвчилсэн үнэлгээний алгоритмаар үнэлэхэд “БАГА” эрсдэлтэй дүгнэгдсэн.
2. Говь-Алтай аймгийн Тайшир суманд бүртгэгдсэн тарваган тахлын сэжигтэй тохиолдлын эрсдэлийг түргэвчилсэн үнэлгээний алгоритмаар үнэлэхэд “ДУНД” эрсдэлтэй дүгнэгдсэн.
3. Төв аймгийн Мөнгөнморьт суманд бүртгэгдсэн боомын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлын эрсдэлийг түргэвчилсэн үнэлгээний алгоритмаар үнэлэхэд “ДУНД” эрсдэлтэй дүгнэгдсэн.
4. Увс аймгийн Зүүнговь суманд бүртгэгдсэн боомын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлын эрсдэлийг түргэвчилсэн үнэлгээний алгоритмаар үнэлэхэд “ДУНД” эрсдэлтэй дүгнэгдсэн.
5. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгээс мэдээлэгдсэн тарваган тахлын вакцины урвал илэрсэн албан хаагчдад эрсдэлийг түргэвчилсэн үнэлгээний алгоритмаар үнэлэхэд “ДУНД” эрсдэлтэй дүгнэгдсэн.

3.2	МУХТЖҮЧ 2.2.1; ЗГҮАХ 1.1.3; Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 5.2.1 Дорноговь, Дорнод, Дархан-Уул, Төв аймагт Зоонозын өвчин судлалын төв, хил дагуух 12 боомтод тандалтын нэгж байгуулах хэрэгцээ, шаардлага, техник эдийн засгийн үндэслэл, тооцооллыг боловсруулна.	-	Салбар ЗӨСТ байгуулах шийдвэр	4 аймагт шинээр ЗӨСТ байгуулах, 12 хилийн боомтод тандалтын нэгж байгуулах тооцоолол үндэслэл, эдийн засаг хөрөнгө оруулалтын тооцоолол, төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан ЭМЯ-нд хүргүүлсэн.	Дорноговь, Дорнод, Дархан-Уул, Төв аймагт ЗӨСТ, хил дагуух 12 боомтод тандалтын нэгж байгуулах саналыг ЭМЯ-нд хүргүүлэн шийдвэрлэж үлсэн байна.	“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний 1.1.3 дахь заалт, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 1.1.3.2 дахь заалтад 2021-2023 онд “6 аймагт Зоонозын өвчин судлалын төв (ЗӨСТ), хилийн 24 боомтод тандалтын нэгж байгуулах”-аар тусгагдсан. Уг ажлын хүрээнд 4 аймагт шинээр ЗӨСТ байгуулах, 5 аймгийн ЗӨСТ-ийн барилгыг шинээр бариулах, 12 хилийн боомтод тандалтын нэгж байгуулах үндэслэл, эдийн засаг, хөрөнгө оруулалтын тооцоолол, төсвийн хүрээний мэдэгдлийг тус төвөөс боловсруулан ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар дэмжүүлэн 15 яамнаас санал авч, ЭМЯ-наас 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 1а/5053 тоот албан бичгээр ЗГХЭГ хүргүүлсэн боловч Хууль зүйн яам, Сангийн яамнаас нэгж байгуулах үйл ажиллагаа дэмжээгүй болно. 2024 онд уг үйл ажиллагаатай холбоотойгоор ЭМЯ-ны НЭМГ-ын дарга Төрийн нарийн бичгийн даргад танилцуулан улмаар Монгол Улсын Сайд, Боомтын Сэргэлтийн Үндэсний хорооны даргад уг асуудлыг танилцуулахаар ЭМЯ-ны зүгээс хандсан боловч тусгайлсан хариу ирүүлээгүй болно.	90%
3.3	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 5.2.6 Тархвар судлалын заалтаар хийгддэг зоонозын өвчний эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийнэ.	20 Олон улсын төсөл, хөтөлбөр	Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	8 аймгийн ЭМГ болон ӨЭМТ нийт 26 дархлаажуулалтын нэгжид дэмжлэг хяналт хийн, зөвлөмж, мэргэжил аргагүйгээр хангаж, сургалт хийсэн.	6 байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийж зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна.	Эрүүл мэндийн Сайдын 2022 оны А/528 дугаар тушаалын “Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх, арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөө”-ний 5.2.7 дахь зорилтод “Тархвар судлалын заалтаар хийгддэг зоонозын өвчний эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагаанд дэмжлэг хяналт хийх” заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төвийн захирлын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан удирдамжийн дагуу дараах үйл ажиллагааг зохион байгууллаа. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвүүд, Гэмтэл согог судлалын үндэсний төв, салбар эмнэлгүүдэд тархвар судлалын заалтаар хийгддэг зоонозын халдварт өвчний дархлаажуулалтын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт үнэлгээ хийлээ. - Галзуу, тарваган тахал, хачигт энцефалит өвчний дархлаажуулалтын цэгийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, хүйтэн хэлхээ, вакцин зарцуулалт, тайлан мэдээтэй танилцаж, зөвлөмж, зөвлөгөө өгсөн. 	100%

						<ul style="list-style-type: none"> - Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдлуудын АШБМ-ын мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн иргэдийн дархлаажуулалтын давтан тунгийн хамрагдалт хангалтгүй байсан тул зөвлөгөө өгч ажиллалаа. - Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэг, Дорноговь аймгийн Замын-Үүд сумдад тарваган тахлын дархлаажуулалтын урвал хүндрэл үүссэнтэй холбоотойгоор дараах үйл ажиллагааг зохион байгууллаа. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Тарваган тахлын дархлаажуулалттай холбоотой нэмэлт зөвлөмжийг боловсруулж, Аймаг, Нийслэлийн ЭМГ, ЗӨСТ-үүдэд хүргүүлсэн. Тарваган тахлын дархлаажуулалттай холбоотой мэдээлэлд дүн шинжилгээ хийж, дархлаажуулалтын дараах урвал хүндрэл, гаж нөлөө, хариу урвал илэрсэн тохиолдол бүрт зөвлөгөө, мэдээллийг 24 цагаар өгч ажиллалаа. - Тарваган тахлын дархлаажуулалттай холбоотой алдаа дутагдал гарахаас урьдчилан сэргийлэх, мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагааны хүрээнд 21 аймгийн халдвар судлагч эмч нарыг оролцуулан сургалт зохион байгуулж, тогтмол зөвлөгөө мэдээллээр хангаж байна. <p>Мөн ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн хамтарсан баг Дорноговь аймгийн Замын-үүд сум, Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэгт ажиллан, тарваган тахлын дархлаажуулалтын үйл ажиллагааг үнэлж, хариу арга хэмжээний талаарх заавар, зөвлөмж өглөө.</p>	
3.4	МУЗГҮАХ 1.1.3; Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал. 5.3.3, 6.4.2. Зоонозын өвчний хариу арга хэмжээний талаар эрүүл мэндийн ажилтныг чадавхжуулна.	100 Төсөл хөтөлбөр,	Зохион байгуулсан сургалтын тоо Сургалтад хамрагдсан хүний тоо	21 аймгийн 129 сумын 2400 эмч мэргэжилтнүүд эд 5 цахим сургалт, 4 танхимын сургалтад хамрагдсан.	Хариу арга хэмжээний тасралтгүй сургалтууд ыг зохион байгуулсан байна.	<p>2024 оны зоонозын халдварт өвчний сургалтын төлөвлөгөө боловсруулан батлуулж, төлөвлөгөөний дагуу дараах сургалтуудыг зохион байгуулсан.</p> <ol style="list-style-type: none"> 1. “Галзуу өвчний эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний бэлэн байдлыг хангах чиглэл”-ээр Нийслэлийн 9 дүүргийн 142 эмнэлгийн мэргэжилтнүүдэд цахим сургалт зохион байгууллаа. 2. ОХУ-ын Эрхүү хот дахь Сибирь Алс Дорнодын Тарваган тахал эсэргүүцэн судлах эрдэм шинжилгээний хүрээлэнд “Oxford Nanopore технологи ашиглан генийн дараалалд дата анализ хийх” 	100%

					<p>дадлага сургалтад Лавлагаа, лабораторийн албаны вирус судлагч эмч, генетикч нар хамрагдсан.</p> <p>3. 21 аймгийн 200 гаруй эмч, мэргэжилтнүүдэд “Хачгаар дамжих зарим халдваруудын байгалийн голомтын төлөв байдал, тархвар судлал, лабораторийн шинжилгээ, эмнэлзүй, ялган оношилгоо, эмчилгээ, дархлаажуулалт” сэдэвт цахим сургалт зохион байгуулсан.</p> <p>4. Нийслэлийн ЗӨСТ-тэй хамтран нийслэлийн 8 дүүрэг, өрх, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн 160 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд “Хачгаар дамжих халдвар”-ын цахим сургалтыг зохион байгуулсан.</p> <p>5. Төвийн 15 эмч мэргэжилтэн, орон нутгийн 12 ЗӨСТ-ийн 16 нян судлагч эмч, генетикч нарт “Молекул биологи болон генийн дараалал тогтоох орчин үеийн судалгааны арга” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.</p> <p>6. Улсын хэмжээнд “Нэг эрүүл мэнд-Зооноз” төслийн хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд “Нэг эрүүл мэнд үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, зоонозын гаралтай хүний болон мал амьтны өвчлөлийн төлөв байдал, салбар болон салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, хэрхэн хамтарч ажиллах” талаар мэдээлэл солилцон дадлагажих сургалтыг зохион байгуулсан бөгөөд уг сургалтад Дэлхийн банк, ЗӨСҮТ, ХӨСҮТ, МЭХ, ШУТИС, Орон зайн Академи, 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн ЭМГ, ЗӨСТ, НЭ, БОЭТ зэрэг 35 байгууллагын 80 гаруй мэргэжилтэн оролцсон.</p> <p>7. ЭМХТ-тэй хамтран тарваган тахал өвчний улиралчлалыг угтуулан улсын хэмжээний ЭМБ-уудад цахим сургалт зохион байгуулсан. Сургалтад аймаг, нийслэлийн ЭМГ, ЗӨСТ, БОЭТ, НЭ, Сум, Өрх, Дүүргийн эрүүл мэндийн төвүүд, Нийслэлийн хүүхдийн сэргээн засах төв, шүдний эмнэлгүүд зэрэг 200 гаруй эрүүл мэндийн байгууллагын 750 мэргэжилтэн хамрагдсан.</p> <p>8. ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр Нийслэл, аймгийн ЗӨСТ, ЗӨСҮТ-ийн нийт 61 лабораторийн эмч, мэргэжилтэн, лаборант нарын онолын мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Зоонозын халдварын оношилгоо, судалгаанд орчин үеийн молекул биологийн аргуудыг хэрэглэх нь” сэдэвт онол, практикийн сургалтыг</p>
--	--	--	--	--	--

						<p>АШУҮИС-ын Молекул биологи-Удам зүйн тэнхимтэй хамтран зохион байгуулсан.</p> <p>Гадаад хамтын ажиллагааны хүрээнд үндэсний төвийн хүний нөөцийг чадавхжуулах бодлогод суурилан 2024 онд 6 улсын 11 сургалтад нийт давхардсан тоогоор 23 эмч, мэргэжилтнүүдийг хамруулж, чадавхжууллаа.</p>	
3.5	<p>Аймаг, нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн мэргэжилтэнүүд болон шинэ мэргэжилтэнүүдэд зориулсан зоонозын өвчийн талаар цахим хичээлийн контент боловсруулж онлайн сургалтын модуль хөгжүүлнэ.</p>	7 Төсөл хөтөлбөр	<p>Боловсруулсан хичээлийн тоо, Цахим сургалтад хамрагдсан мэргэжилтэний тоо</p>	<p>Коронавируст халдварын үед цахим интерактив хичээл бэлтгэн цахимаар хичээл орж байсан.</p>	<p>Цахим хичээлийн контент боловсруулж онлайн сургалтыг зохион байгуулсан байна.</p>	<p>Зоонозын халдварт өвчний агуулгыг бүрэн багтаасан 12 цахим сургалтын модуль хичээл боловсруулж, төвийн цахим хуудсанд байршуулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Тарваган тахал - Галзуу - Боом - Хачгаар дамжих халдвар - Токсоплазмоз - Бэтэг - Хумхаа <p>Дээрх цахим хичээлүүдийн хандалтын тоо 1091 байна.</p> <p>Уг цахим модуль хичээл нь эрүүл мэндийн болон бусад холбогдох салбарын мэргэжилтнүүд зоонозын халдварт өвчний тохиолдлын үед ажиллах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахад мэргэжил арга зүйн мэдээллээр хангах зорилготой юм.</p> <p>Хичээлүүдийн холбоос: 202.70.43.59 /edu/</p>	100%
Зорилт 4. Лабораторийн лавлагаа тусламж, үйлчилгээг хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх, био үйлдвэрлэлийг хөгжүүлэх							
4.1	<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 6.5.1 Лабораторийн үйл ажиллагаанд Эрүүл мэндийн лаборатори-Чанар чадавхид тавих шаардлага MNS ISO 15189:2015 стандартыг хэрэгжүүлж ажиллана.</p>	Улсын төсөв	<p>Шинээр боловсруулсан болон Сайжруулсан ШСАЗ,ТСА 3 ШАЗ, ТАЗ-ын тоо</p>	<p>Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2023 оны 12 сарын 06-ны өдрийн А/228 тоот тушаалаар итгэмжлэгдсэн.</p>	<p>Эрүүл мэндийн лаборатори-Чанар чадавхид тавих шаардлага MNS ISO 15189:2015 стандартыг хэрэгжүүлж ажилласан байна.</p>	<p>Шинэчлэгдэн батлагдсан "MNS ISO 15189:2024 ЭРҮҮЛ МЭНДИЙН ЛАБОРАТОРИ-ЧАНАР, ЧАДАВХАД ТАВИХ ШААРДЛАГА" сэдэвт стандарт таниулах сургалтад ЗӨСҮТ-ийн 6, Өвөрхангай аймгийн ЗӨСТ-ийн 3 нийт 9 эмч, мэргэжилтэн хамрагдан сертификат авсан. MNS ISO 15189:2015 стандартын хүрээнд;</p> <ul style="list-style-type: none"> - Шинээр боловсруулсан ЗӨСҮТ-ЛЛА-ШАЗ 14 - Сайжруулалт хийж, нэмэлт өөрчлөлт оруулсан ЗӨСҮТ-ЛЛА-СШАЗ 3 - Шинээр боловсруулсан журам 1, нэмэлт өөрчлөлт оруулсан журам 1 - Дотоод аудитын хуваарь, хөтөлбөрийн дагуу 4 хүний бүрэлдэхүүнтэй баг томилж, дотоод аудит хийж, тайланг Удирдлагын багт танилцуулан, залруулга хийж тогтмолжууллаа. 	100%

						<ul style="list-style-type: none"> - Үндэсний итгэмжлэлийн төвөөс ирүүлсэн зөвлөмжийн 2,3,7 заалтуудыг 100% хэрэгжүүлж ажилласан. - Төвийн 11 оношилгооны лабораторид нүд угаах нэг удаагийн төхөөрөмж, анхны тусламжийн хайрцаг суурилуулсан. 	
4.2	<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 6.5.3</p> <p>Зоонозын халдварт өвчний үүсгэгчийн геномын бүрэн дараалал тодорхойлох судалгааны ажил хийнэ.</p>	Улсын төсөв	Судалгааны ажлын тайлан	<p>2023 онд NGS аппаратыг суурилуулж, эмч мэргэжилтнийг сургаж хачигт риккетсиоз, SARS-CoV2 өвчний үүсгэгчийн генийн дараалалыг тогтоосон.</p>	<p>Үүсгэгчийн генотип, полиморф изоомын судалгааг хийсэн байна.</p>	<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/258 дугаар тушаалын 6.5.3 дахь зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгууллаа.</p> <ol style="list-style-type: none"> 1. 2023 онд ISEQ 100 системд уншуулж, шинжилгээнд хамруулсан хачигт риккетсиоз өвчний үүсгэгчийн генийн түүхий дараалалд дата анализ боловсруулалт бүрэн хийж, гүйцэтгэсэн 2. Тарваган тахлын сонгогдсон 80 омогт II үеийн (NGS) генийн дараалал тогтоох аргаар антибиотик тэсвэржилтийн ген, төрөл зүйлийн тархалт, мутацийн судалгааг хийж, Удирдлагын зөвлөлийн №3 дугаар хуралд танилцуулан цаашид хэрэгжүүлэх чиглэлийг тодорхойлсон. 	100%
4.3	<p>Лабораторийн үйл ажиллагаанд Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018 стандартаар итгэмжлүүлэх бэлтгэх ажлыг хангана.</p>	Улсын төсөв	Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	<p>Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2023 оны 12 сарын 06-ны өдрийн А/228 тоот тушаалаар MNS ISO 15189:2015 итгэмжлэгдсэн.</p>	<p>Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018 стандартаар итгэмжлүүлэх бэлтгэх ажил</p>	<p>Лабораторийн үйл ажиллагааг Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018 стандартаар итгэмжлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. MNS ISO 17025:2018 стандартаар итгэмжлүүлсэн “Хэлт энд Сэфти Солушинс” ХХК, “Энхийн шүүдэр” ХХК, “Нахиа импекс” ХХК, “УМЭАЦТЛ”-ийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалсан. 2. Үндэсний итгэмжлэлийн төвд “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018 стандарт” таниулах сургалтад 5 албаны 35 эмч мэргэжилтнүүдийг хамруулж, сертификат авсан. 3. Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018 стандартын өөрийн үнэлгээний хуудсыг 5 бүлгийн дагуу үнэлгээжүүлсэн. 	100%

					эхэлсэн байна.	<p>4. ЗӨСҮТ, Нийслэл, аймгийн ЗӨСТ-ийн сүлжээ лабораторийн итгэмжлэлийн хүрээ боловсруулсан.</p> <p>5. ЗӨСҮТ, Нийслэл, аймгийн ЗӨСТ-ийн сүлжээ лабораториудад хөтлөгдөх АШБМ-ыг төвийн захирлын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/66 тушаалаар баталгаажуулан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.</p> <p>6. Тарваган тахал, боом, холер өвчний ШСАЗ-д нэмэлт өөрчлөлт оруулан дотооддоо баталж, мөрдөн ажиллаж байна.</p> <p>7. ХАБҮЛЛ-тай хийсэн хамтын ажиллагааны 24/16-01 дугаартай гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж “Ур чадварын сорил” хөтөлбөрт Нийслэл, аймгийн ЗӨСТ-үүдийн мэргэжилтнүүдийг 100% хамруулсан.</p>	
4.4	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 6.5.2 Аймаг, нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн лабораторийн оношилгооны чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.	Азийн Хөгжлийн банк	Молекул биологийн шинжилгээ нэвтрүүлсэн салбарын тоо Шинжилгээн ий тоо	14 салбар төвд молекул биологийн иж бүрэн лаборатори байгуулж, 7 салбар төвд молекул биологийн шинжилгээг нэвтрүүлснээр нийт 1152 сорьц шинжилж 352 сорьц эерэг дүнтэй гарсан.	7 аймгийн ЗӨСТөвийн лабораторит молекул биологийн шинжилгээг нэвтрүүлсэн байна.	<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаалын 6.5.2 дахь заалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд зоонозын халдварт өвчний тохиолдол бүрийг орон нутагт оношлох чадавхыг бүрдүүлж, хэрэгжүүлснээр орон нутагт цаг алдалгүй оношлох, тохирсон хариу арга хэмжээг зохион байгуулах, сорьц тээвэрлэлт, дэгдэлтийн үеийн хөл хорионы хугацаа богиноссоноор нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулсан. Дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 9 аймгийн ЗӨСТ-д молекул биологийн оношлуур, урвалж захиалах зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж байна. 7 аймгийн ЗӨСТ-ийн лабораторийн эмч нарт молекул биологийн оношилгооны тоног төхөөрөмж, суурилуулалтад цахим хэлбэрээр зөвлөгөө, зөвлөмж өгсөн. “Молекул биологи болон генийн дараалал тогтоох орчин үеийн судалгааны арга” сэдэвт сургалт зохион байгуулж, 12 аймгийн 17 лабораторийн эмч мэргэжилтнүүд хамрагдсан. Эрүүл мэндийн сайдын 2024 оны 05 дугаар сарын 27, 30-ны өдрийн А/238, А/251 дугаар тушаалын дагуу 3,424,766,203₮ үнэ бүхий молекул биологийн иж бүрэн лабораторийн тоног төхөөрөмжийг Нийслэл, аймгийн ЗӨСТ-ийн 14 лабораторит шилжүүлэн аймаг орон нутагт зоонозын халдварт 	100%

						өвчний оношийг хурдан шуурхай тогтоох чадавхыг бүрдүүлэн ажиллаж байна.	
4.5	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 6.5.1 Чанарын гадаад хяналтын ур чадварын сорилын хөтөлбөрт хамрагдана.	Улсын төсөв	Баталгаажуулсан сорьцын тоо	2023 онд Лабораторийн гадаад чанарын хяналтад нян судлал, молекул биологийн чиглэлээр 3 удаа хамрагдаж, хангалттай үнэлгээ авсан.	Гадаад чанарын хяналтын үнэлгээнд орсон байна.	ХАБҮЛЛ, ЗӨСҮТ-ийн Ур чадварын үнэлгээнд хамрагдах 24/16-01 тоот гэрээг 2 жилийн хугацаатай байгуулсан. Тайлант хугацаанд 2 удаагийн ур чадварын сорилд хамрагдан нийт 9 сорьц хүлээн авч, хариуг тухай бүр хүргүүлэн ажилласан. Үүнд: 1. Тайланд улсын Чулалонгкорн Их сургуулийн Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгээс ирүүлсэн нян судлалын ур чадварын сорилд хамрагдаж, 7 нянгийн булингыг шинжилж, 5 нянгийн булингад <i>E.Coli</i> үүсгэгч болохыг баталгаажуулж, хариуг хүргүүлсэн. 2. ХАБҮЛЛ-ийн эхний хагас жилийн нян судлалын ур чадварын сорилд хамрагдаж, 2 нянгийн булингыг шинжилж, 1 сорьцноос <i>L.Monocytogens</i> үүсгэгч болохыг баталгаажуулж, хариуг хугацаанд нь хүргүүлж “Хангалттай” үнэлгээ авсан.	100%

4.6	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 6.5.4 Эс өсгөвөрлөх судалгааны ажил хийнэ.	-	Судалгааны ажлын тайлан	2018 онд ВНК-21 эсэд хачигт энцефалитын вирусыг өсгөвөрлөж хачигт энцефалитын вирусн нутгийн 15 омогтой болсон.	Эс өсгөвөрлөх аргыг нэвтрүүлэх судалгааны ажлын тайлан гарсан байна.	Мал эмнэлгийн хүрээлэн болон тус төвийн хамтын ажиллагааны 24/16-02 тоот гэрээг 1 жилээр байгууллаа. Уг гэрээний хүрээнд “2023 онд хачигт энцефалит өвчнөөр нас барсан өвчтөний эмгэг судлалын сорьцыг ВНК-21 эсэд өсгөвөрлөж нутгийн омог гаргах судалгааны ажил” удирдамж (№2)-ийн хүрээнд хамтран эс сэргээх 6 удаагийн дамжуулалт бүхий үйл ажиллагааг хийж эс эмгэгшүүлэн, өсгөвөрлөгдсөн эсэд 2 удаа бцУТ-ПГУ-аар баталгаажуулан хачигт энцефалитын 3 вирус өсгөвөрлөсөн тайланг боловсруулж, Удирдлагын багт танилцууллаа.	100%
4.7	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 6.5.1 Өвөрхангай, Увс, Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн лабораторит MNS ISO 15189:2015 стандартын шаардлага хангах үйл ажиллагаанд зөвлөн туслна.	100 Төсөл хөтөлбөр	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2023 оны 12 сарын 06-ны өдрийн А/228 тоот тушаалаар итгэмжлэгдсэн.	Батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган ажиллана.	Өвөрхангай, Увс аймаг, Нийслэлийн ЗӨСТ-ийн лаборатори MNS ISO 15189:2015 стандартын шаардлага хангах үйл ажиллагаанд зөвлөн туслах ажлын хүрээнд: 1. “Удирдлага болон Техникийн шаардлага “-ын 4.3-4.15 болон 5.1-5.3, 5.6 –р шаардлагын биелэлтэд тогтмол хяналт тавин, илэрсэн үл тохирлыг сайжруулах арга хэмжээ авч, ЧГА бусад баримт бичгийг бүрдүүлэн ҮИТ-д өргөдөл, хүсэлтийг хүргүүлсэн. 2. Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 01/218 дугаар албан бичгийн дагуу сүлжээ лабораториуд нэгдсэн нэг удирдлага, нэг бодлого нэгдсэн зохион байгуулалтаар итгэмжлэгдэх болсон тухай чиглэл хүлээн авч, 2025 онд хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөлөө. 3. Увс, Нийслэлийн ЗӨСТ-д Б түвшний баримт бичгийн боловсруулалтыг хэрхэн хийх талаар 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, тогтмол зөвлөгөө мэдээллээр ханган ажиллаж байна.	100%
4.8	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулна.	Улсын төсөв	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Химийн хорт болон аюултай бодисын байгаль орчны нарийвчлсан үнэлгээг хийлгэсэн	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулсан байна.	“Зоонозын өвчин судлалын ариутгал халдваргүйтгэл, био үйлдвэрлэлийн лаборатори” төслийн 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд БОУАӨЯ-д хянуулан, батлуулсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу биелэлтийн тайланг БОУАӨЯ-ны цахим флатформоор хугацаанд нь хүргүүлсэн.	100%
4.9		Улсын төсөв		7 удаагийн хуурайшуулалтаар 31.3л үндсэн болон	Хуурайшуулсан тэжээлт орчин	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаалын 6.5.6 дугаар заалтыг хэрэгжүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгууллаа.	100%

	<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 6.5.6. Хуурайшуулсан тэжээлт орчин хэрэглээнд нэвтрүүлнэ.</p>		<p>Хуурайшуулсан тэжээлт орчны тоо</p>	<p>ялган оношлогч тэжээлт орчнууд хуурайшуулсан</p>	<p>үйлдвэрлэж ЗӨСТ-үүдэд туршилтаар өгч үр дүнг тооцож хэрэглээнд нэвтрүүлнэ</p>	<ol style="list-style-type: none"> 1. Тэжээл хуурайшуулалтын ажлын 2024 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу 3 төрөл 3 серийн 8.6л өтгөрүүлсэн шөлийг (шингэнээр 48.2л) бэлтгэн 5 удаагийн хуурайшуулалт хийлээ. Хуурайшуулсан бүтээгдэхүүнээр 6 төрлийн 7 серийн үндсэн тэжээлт орчин бэлтгэн ЭЗЧХЛ-т шалгуулж, бүгд чанарын шаардлага хангасан. 2. Хуурайшуулсан бүтээгдэхүүнийг НЭМҮТ-ийн НЭМҮЛЛ-т давсны агууламж, үнслэгийн хэмжээ тодорхойлох шинжилгээ, МЭЭСБУЛ лабораторит химийн болон нян судлалын 8 үзүүлэлт тодорхойлох шинжилгээнд тус тус хамруулж, үнэлүүлээ. 3. 2023 онд шинээр худалдан авсан холигч бутлагчийг ашиглан хатуу тэжээлт орчин бэлтгэх болон тэжээлт орчны бүх орц найрлагыг хуурайгаар холих туршилтыг хийж, нийт 6 төрөл, 12 серийн үндсэн, 2 төрлийн 2 серийн өвөрмөц тэжээлт орчин бэлтгэн ЭЗЧХЛ-т нян судлалын аргаар шалгуулахад чанарын шаардлага хангаж, оношилгоонд ашигласан. 4. 2024 онд хуурайшуулсан тэжээлт орчнууд болон Хоттингерийн гидролизатад физик, химийн шинжилгээнүүдийг (үлдэгдэл чийг, рН, давсны агууламж, амино азот тодорхойлох) хийв. 5. Хуурайшуулсан тэжээлт орчинг лабораторийн судалгаа шинжилгээ, хээрийн шинжилгээнд ашиглан үр дүнг ирүүлэх тухай 16/370 албан тоотыг аймаг нийслэлийн ЗӨСТ-үүдэд илгээж, 4 төрлийн туршилтын тэжээлт орчныг хүргүүлсэн. 5 аймгийн ЗӨСТ-д дээж хүргүүлснээс Архангай, Өвөрхангай, Багануур, Баянхонгор аймгуудаас тэжээлт орчинг хэрэглэсэн тухай илтгэх хуудас ирүүлж, ашиглалтын үйл ажиллагаанд дүгнэлт хийлээ. 6. ЗӨСҮТ-ийн тарваган тахлын лабораторит Баян-Өлгий аймгийн тандалт судалгааны ажлаар илрүүлсэн 5 өсгөврийн өсгөвөр судалгааны ажилд хуурайшуулсан тэжээлт орчныг давхар хэрэглэн дүгнэлт боловсруулж гаргасан. 7. 2024 онд хуурайшуулалтын ажлын хүрээнд хийсэн ажлын илтгэх хуудсыг боловсруулан 2024 оны Удирдлагын зөвлөлийн №3 дугаар хуралд танилцуулсан. 	
--	--	--	--	---	--	--	--

4.10	“Алсын хараа-2050” 2.2.28; ЗГУАХ 2.1.8.7; Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаал 6.5.6 Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл авна.	Улсын төсөв	Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрлийн гэрчилгээ	Химийн хорт болон аюултай бодисын байгаль орчны нарийвчлсан үнэлгээг хийлгэсэн	Химийн хорт болон аюултай бодис ашиглах тусгай зөвшөөрөл БОАЖЯ-наас авсан байна.	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан, химийн бодисын жагсаалт, хор аюулын лавлагаа, НБОГ-ын шинжээчийн дүгнэлт зэрэг холбогдох материалуудыг үндэслэн Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, ашиглах 5 жилийн хугацаатай тусгай зөвшөөрлийг БОУАӨЯ - аас олгосон. Гэрчилгээний дугаар №0000004.	100%
4.11	Шимэгч судлалын лабораторид ISO 17025 стандартыг нэвтрүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	50 Төсөл хөтөлбөр	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Магадлан итгэмжлэлд ISO 17025 нэвтрүүлэх ажлын хүрээнд хачгийн судалгааны стандарт ажиллагааны зааврыг боловсруулсан.	Шимэгч судлалын лабораторийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор төлөвлөгөө боловсруулан батлуулах, төлөвлөгөө ний дагуу арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	MNS ISO/IEC 17025:2018 стандартыг үе шаттай нэвтрүүлэх ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүллээ. Үүнд: 1. Төвийн ариутгал халдваргүйтгэл био үйлдвэрлэлийн албаны 15 эмч, мэргэжилтнүүд “Сорилын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018 стандарт” сэдэвт таниулах сургалтад 100% хамрагдаж сертификат авсан. 2. Шимэгч судлалын лабораторит морфологийн шинжилгээ хийгддэг бүүрэг, хачиг, шумуулын хоёр стандарт ажиллагааны зааврыг олон улсын удирдамж, зааварт нийцүүлэн боловсруулсан. 3. Тус төвийн шимэгч судлалын лабораторийн АШБМ-уудыг Төвийн захирлын 2024 оны А/66 тоот тушаалаар шинэчлэн батлуулан, мөрдөн ажиллаж байна.	100%
Зорилт 5. Эрдэм, шинжилгээ судалгааг хөгжүүлэх							
5.1	Зоонозын өвчний эрдэм шинжилгээ, судалгааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлно.	Улсын төсөв	Батлагдсан тушаал	Зоонозын өвчний эрдэм шинжилгээ, судалгааны тэргүүлэх чиглэл (2017-2021)-ийг боловсруулан төвийн захирлаар	Эрдэм шинжилгээ, судалгааны тэргүүлэх чиглэлийг батлуулсан байна.	Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 249 дүгээр тогтоолоор Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг шинэчлэн батлагдсантай холбогдуулан Төвийн 2024-2027 оны стратеги төлөвлөгөөтэй уялдуулан Зоонозын өвчний эрдэм шинжилгээ, судалгааны тэргүүлэх чиглэл (2017-2021)-ийг боловсруулж, 2024 оны Удирдлагын зөвлөлийн №9 дүгээр хурлаар хэлэлцүүлэн, төвийн захирлын 2024 оны А/72 дугаар тушаалаар батлуулж, мөрдлөг болгон ажиллаж байна.	100%

				батлуулж, хэрэгжүүлсэн.			
5.2	“Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл”-ийн 2024 оны 5 дугаарыг эрхлэн гаргана.	Улсын төсөв	2024 онд ОУ-ын 1, дотоодын хамтын ажиллагааны хүрээнд 3 судалгаа шинжилгээ гүйцэтгэсэн.	Тус төв нь “Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл”-ийн нэг дугаарыг жил бүр эрхлэн гаргадаг. 2023 оны 5-р дугаарыг эрхлэн гаргасан.	“Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл” хэвлүүлэхэд хамтран ажиллаж, сэтгүүл хэвлүүлсэн байна.	Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүлийн редакцийн зөвлөлийн 2024 оны анхдугаар хуралд төвийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга оролцож, тус сэтгүүлийг эрхлэн гаргах хуваарийг батлуулсан. Тус сэтгүүлийн 2024 оны 10 дугаар сарын Тав дахь дугаарт 3 өгүүлэл, 1 тойм, 1 эпином нэр томъёо, 5 ажиглалт мэдээг хэвлүүлэн, олны хүртээл болгосон.	100%
Зорилт 6. Удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, нийгмийн хамгааллыг сайжруулах							
6.1	“Нэг эрүүл мэнд-Зооноз” сэдэвт үндэсний зөвлөлдөх уулзалтыг салбар хоорондын төлөөлөл оролцуулан зохион байгуулна.	70 Төсөл хөтөлбөр	Уулзалтад оролцсон байгууллагын тоо, Оролцогчдын тоо	“Нэг эрүүл мэнд - зооноз” сэдэвт үндэсний хэлэлцүүлэг төв, баруун, зүүн бүсийн аймгуудад зохион байгуулсан.	”Нэг эрүүл мэнд-Зооноз” сэдэвт үндэсний зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан байна.	2024 оны 05 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд “Нэг эрүүл мэнд-Зооноз” төслийн хүрээнд нэг эрүүл мэнд үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, зоонозын гаралтай хүний болон мал амьтны өвчлөлийн төлөв байдал, салбар болон салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “ЗООНОЗЫН ӨВЧНИЙ МОНОГРАФ, ТАНДАЛТЫН ЗААВАР, СТАНДАРТ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР, ZIS, Arc GIS ПРОГРАММЫН ХЭРЭГЛЭЭ” сэдэвт эмч мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтыг зохион байгуулсан. Хиймэл оюун ухааныг зоонозын өвчний оношлогоо, хяналтын арга хэмжээнд ашиглах боломж, зоонозын мэдээллийн систем ба ЗИС-ийн хэрэглээ, орон нутгийн практик үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд тулгамдаж буй асуудал, шийдэл, газарзүйн мэдээллийн систем программын хэрэглээ сэдэвт шинэлэг сэдвүүдийг хөндлөө. Тус сургалтад Дэлхийн банк, ЗӨСҮТ, ХӨСҮТ, МЭХ, ШУТИС, Орон зайн Академи, 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн ЭМГ, ЗӨСТ, НЭ, БОЭТ зэрэг 35 байгууллагын 80 гаруй мэргэжилтнүүд оролцсон.	100%

6.2	Байгууллагын тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулан батлуулна.	-	Батлагдсан төлөвлөгөө	5 зорилтын 25 арга хэмжээг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	<p>“Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө”-г 100 % хэрэгжүүлэн ажиллалаа. 2024 оны төвийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийг тогтоох дэмжлэгт хяналт хийх хуваарь, батлагдсан удирдамжийн дагуу доорхи дэмжлэгт хяналт, шинжилгээ-үнэлгээг хийж, холбогдох үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Лабораторид ашиглагдаж буй бараа материалын зарцуулалт, био үйлдвэрлэлийн лабораторит хийгдэж буй тарваган тахал, хуурмаг сүрьеэгийн нян залгиур үйлдвэрлэлийн явцын хяналт, амьтны байрны үйл ажиллагааны чанар, аюулгүй байдал, байгууллагын баг, хороо, зөвлөлийн үйл ажиллагаа, Зоонозын мэдээллийн системийн үйл ажиллагаанд чанар, аюулгүй байдал, амь сорьцын лабораториудын үйл ажиллагаа, мэрэгчийн дуудлагын тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал зэрэг үйл ажиллагаанд батлагдсан удирдамжийн дагуу 15 удаа чанарын хяналт үнэлгээ, дэмжлэгт хяналт хийн илтгэх хуудас бичиж, тухай бүр Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн үүрэгжүүлж, зөвлөмж боловсруулан хүргүүлэн, хэрэгжилтэд эргэн хяналт хийж ажилласан. 2. Ижил мэргэжилтний үнэлгээг Төвийн ерөнхий захирлын 2020 оны А/66 тоот тушаалын “Эрүүл мэндийн ажилтны үнэлгээний ерөнхий маягт”-ын дагуу хагас, бүтэн жилээр давхардсан тоогоор 120 гаруй албан хаагч хамруулж, үнэлгээний дүнг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, үүрэгжүүлэн ажиллалаа. 3. Төвийн захирлын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/03 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн байгууллагын магадлан шинжлэх шалгуур үзүүлэлтийн өөрийн үнэлгээний бэлтгэл ажлын төлөвлөгөө”, “Магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүн”-ийг томилон, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. <p>Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд үүссэн дараах эрсдэл, тохиолдлуудыг бүртгэн хариу арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:</p>	100%
-----	---	---	-----------------------	--	---	---	------

						<ol style="list-style-type: none"> 1. “2023 онд илрүүлсэн Y.pestis зүйлийн омгийн нарийвчилсан судалгаа”-ны явцад амин хүчил тодорхойлох сорил, кальцийн ионоос хамаарах шинж тодорхойлох сорил, нөсөө шингээх шинж тодорхойлох сорилуудын үр дүн нянгийн бохир ургалт үзүүлсэн тохиолдол 2. Шинэ ажилтны дагалдан сургалтын явцад мах пептоны шөл тунадасжин бохирдсон тохиолдол 3. Мэдээллийн системийн үйл ажиллагаанд алдаа илэрч буй тохиолдлыг бүртгэн тухай бүр хяналт үнэлгээ хийж, үүссэн тохиолдлыг арилгуулах арга хэмжээг зохион байгуулан, хугацаатай зөвлөмж өгч, хэрэгжилтэд эргэн хяналт хийж ажилласан. 	
6.3	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.	Улсын төсөв	Төлөвлөгөө ний Хэрэгжилтийн хувь	2023 онд Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлж тайлагнасан.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	<p>2024 онд төвийн эмч, мэргэжилтнүүдийн нийгмийн баталгааг хангах 14 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг 100 хувь биелүүлэн ажилласан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Худалдаа хөгжлийн банктэй хамтран ажиллах гэрээг шинэчлэн баталж, 4 ажилтан орон сууцны байрны зээлд оочир дараалалгүй хамрагдаж, зээлийн шийдвэр гаргуулсан. 2. Эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах, ажлын байрны хувцас хэрэглэлээр хангах, эмч, мэргэжилтнүүдийг гадаадын улс орны сургалтад хамруулж, мэргэжил дээшлүүлэх, урамшуулал, буцалтгүй тусламж олгох зэрэг нийгмийн хамгааллын талаар хэрэгжүүлэх үйл ажиллагаануудыг зохион байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан. 3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/221 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан (2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхээр батлагдсан) “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-д санал боловсруулан хүргүүлж, энэхүү жагсаалтын “Хөдөлмөрийн хортой нөхцөл”-ийн 2.17, 2.22, “Хөдөлмөрийн хүнд нөхцөл”-ийн 4.25, 4.26 дахь заалтуудаар тус төвийн нөхцөлд хамаарах ажил мэргэжлийг тусгуулан, энэхүү тушаалтай холбоотой холбогдох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажилласан нь хортой нөхцөлд хамаарах ажил, мэргэжлээр ажиллаж буй эмч, 	100%

						<p>эмнэлгийн мэргэжилтнүүдийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр томоохон ажил болсон.</p> <p>4. Зоонозын салбарын ажилтан, албан хаагчдын цалин орлого, нийгмийн баталгааг хангах зорилгоор 2023 оноос эхлэн салбарын онцлог, ажлын байрны эрсдэлт орчныг бодлого боловсруулах эрх бүхий байгууллагуудад шат дарааллан танилцуулсны үр дүнд 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Монгол Улсын Засгийн Газрын 12 дугаар тогтоолоор тус төвийн албан хаагчдын хөдөлмөрийн нөхцлийн нэмэгдлийг 30 хувиар тогтоолгож, албан тушаал эрхлэх хугацаанд сар бүр олгох эрх зүйн орчныг баталгаажуулсны дагуу олгож байна.</p>	
6.4	Байгууллагын санхүүгийн удирдлагыг үр ашигтай хэрэгжүүлж, өр авлагагүй ажиллана.	-	Өр авлагын хэмжээ	Өр авлага байхгүй	Өр авлагагүй ажилласан байна.	<p>2024 онд жилийн нийт 4,749.7 сая төгрөгийн төсөвтэйгээр төвийн үндсэн болон дэмжих үйл ажиллагааг төсвийн шууд захирагчийн хууль, эрх зүйн хэм хэмжээнд тохируулан өр, авлагагүйгээр зохион байгуулан ажиллалаа.</p> <p>1. 2024 оны 1 дүгээр сарын байдлаар нийт 31.6 сая төгрөгийн ХХОАТ, НДШ, түлш халаалтын зардлын өр үүссэнийг 2024 оны батлагдсан төсөвтөө Сангийн сайдын 73-р тушаалын хавсралт-1 “зардлын бүлэг хооронд шилжүүлэх” саналыг Эрүүл мэндийн яаманд удаа дараа албан тоотоор хүргүүлсэний үр дүнд 30.55 сая төгрөгийн өрийг барагдуулж, 2024 оны хагас жилийн санхүүгийн тайлангаар 1.05 сая төгрөгийн өртэй санхүүгийн тайлан гарсан.</p> <p>2. Жилийн эцэст өр үүсэх магадлалтай зардлын тооцоолол төлөвлөгөөг удирдлагын багийн түвшинд боловсруулж, дотоод зохион байгуулалтыг хийж, Эрүүл мэндийн яам болон Сангийн яаманд албан тоотоор санхүүжилт хүссэний үр дүнд 64.5 сая төгрөгийн санхүүжилт шийдэгдэж, 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг өр, авлагагүйгээр гаргалаа.</p>	100%
6.5	Төрийн албаны тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг Төвийн чиг үүргийн хүрээнд зохион байгуулах, Онц чухал мэдээллийн дэд	Улсын төсөв	Батлагдсан төлөвлөгөө ний хэрэгжилтийн хувь	Кибер аюулгүй байдлын тухай хууль тухай батлагдсантай холбогдуулан Монгол улсын Эрүүл мэндийн	Кибер аюулгүй байдлын тухай хууль тухай хууль, Төрийн	<p>Монгол улсын Засгийн газрын 2022 оны 207 дугаар тогтоолоор батлагдсан Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтад багтсан бөгөөд "Кибер аюулгүй байдлын тухай" хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.5, 19.2.6 дахь заалтад заасан үүргийн дагуу байгууллагын мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн</p>	100%

	бүтэцтэй байгууллагын үүргийг хэрэгжүүлнэ.			сайдын 2022 оны А/03 албан даалгаврын хүрээнд бие даасан төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал тутамд Эрүүл мэндийн яаманд хүргүүлж байсан.	болон албаны нууцын тухай хууль, Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх хөтөлбөр батлуулан, хэрэгжүүлсэн байна.	аюулгүй байдлын аудитыг 2024 онд багтаан хийхээр төлөвлөн ажиллаж байна. 1. Уг үйл ажиллагаатай холбогдуулан мэдээллийн аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ, аудит хийлгэхээр "Sistem center" ХХК-тай холбогдон хамтран ажиллах тохиролцоонд хүрч, Эрсдлийн үнэлгээ, аудитын ажлын хүрээг тодорхойлон ТЕГ-т Киберь аюулгүй байдлын чиглэлээр сургалт авах, Мэдээллийн аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ, аудит хийлгэх тухай хүсэлтийг албан тоотой хүргүүлсэн. 2. Тус хүсэлтийн хүрээнд ТЕГ-аас Мэдээллийн аюулгүй байдлын талаар хэрэгжүүлж буй бодлого, өнөөгийн нөхцөл байдлын талаар сургалт зохион байгуулсан бөгөөд Мэдээллийн аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ, аудитыг 2025 оны эхний хагас жилд багтаан хийж гүйцэтгүүлэхээр төлөвлөж, хамтран ажиллаж байна.	
6.6	Төвийн дотоод үйл ажиллагаанд ERP систем нэвтрүүлнэ.	Улсын төсөв	Хэрэгжилтийн хувь	Байгууллагын дотоод үйл ажиллагаанд албан бичиг төлөвлөлт, мэдээ, мэдээлэл солилцох дотоод сүлжээ, албаны цахим шуудан болон Viber программыг ашигладаг. Гаднын байгууллагаас ирж буй болон илгээж албан тоотыг ABLE систем ашиглан явуулдаг.	Төвийн дотоод үйл ажиллагаанд ERP системийг бүрэн нэвтрүүлсэн байна.	Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /ERP/-ийг үе шаттай нэвтрүүлэн ажиллаж байна. Уг ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг цахимжуулан ажиллаж байна. 1. Цахим системд байгууллагын мэдээллийг бүрэн оруулсан. 2. Албан хаагчдын албан тушаал болон холбогдох мэдээллүүдийг бүрэн оруулсан. 3. Системд шууд нэвтрэн орох боломжоор хангасан. Бүх мэргэжилтэн mobile app-аар бүрэн нэвтрэн орж ашиглаж байна. 4. ERP mobile хувилбарын гарын авлага бэлтгэн гаргаж, албан хаагчдад танилцуулсан. 5. ERP-ийн нэвтрэн орох заавар гарын авлага бэлтгэн 3 удаа албан хаагчдын сүлжээнд байршуулан мэдээ, мэдээллээр тогтмол хангаж, хяналт тавин ажиллаж байна. 6. ERP E-Mongolia системийг төвийн дотоод үйл ажиллагаа, албан бичиг хэрэг хөтөлөлтөд ашиглах тухай албан тоотыг боловсруулан, ЭМЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн. 7. Албаны дарга нарт сургалт зохион байгуулсан. Үр дүн: Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /ERP/ нэвтрүүлснээр албан бичгийн дамжилт 100% цахимжиж	100%

						цаас болон бичиг хэргийн зардал буурсан. Мөн албан хаагчдын ирцийн бүртгэл болон гадуур ажлын бүртгэлийг цахимжуулах ажлуудыг үе шаттай нэвтрүүлж байна.		
6.7	Зоонозын удирдах зөвлөгөөн байгуулна.	салбарын ажилтны зохион	-	Зөвлөгөөнд оролцсон байгууллага, хүний тоо	2023 онд “Лабораторийн тусламж, үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх нь” зорилтын хүрээнд зохион байгуулсан. Уг зөвлөгөөнд 40 гаруй мэргэжилтнүүд оролцсон.	Зоонозын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулсан байна.	Зоонозын салбарын Удирдах ажилтны зөвлөгөөн – 2024 “Зоонозын халдварт өвчний тусламж, үйлчилгээний чадавхыг бүсчлэн хөгжүүлэх нь” зорилтын хүрээнд өнөөдөр буюу 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр Зоонозын өвчин судлалын үндэсний төв зохион байгуулсан. Энэ удаагийн зөвлөгөөний зорилго нь зоонозын өвчин судлалын салбар нь үйл ажиллагаагаа “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд орон нутгийг бүсчлэн хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасган бүсүүдийн хөгжлийн түвшинг эрэмбэ дараатай дээшлүүлэх зорилгоор салбар бүрийг бүсчлэн хөгжүүлэхээр ажиллаж байгаа үзэл баримтлал” руу чиглүүлж, удирдлагын түвшинд зөвлөлдөж, цаашдын үйл ажиллагаагаа төлөвлөснөөрөө онцлог болсон.	100%
6.8	Хүний нөөцийн бодлогын бичиг боловсруулан батлуулна.	баримтыг	-	Батлагдсан баримт бичиг	2017-2021 онд төвийн хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсруулан, хэрэгжүүлсэн.	Зоонозын салбарын хэмжээнд 2024-2028 оны хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлнэ.	Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр (2024-2027 он)-ийг төвийн Стратеги төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, 2024 оны Удирдлагын зөвлөлийн №15 дугаар хурлаар хэлэлцүүлэн төвийн Захирлын 2024 оны 71 дүгээр тушаалаар батлуулан, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.	100%
6.9	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, гэгээрүүлэх хэмжээний хэрэгжүүлнэ.	урьдчилан соён арга төлөвлөгөөг	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 онд төлөвлөгөө боловсруулан 100% хэрэгжүүлсэн.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн Авлигын эсрэг үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг төвийн захирлаар батлуулан, хэрэгжилтийн ханган ажилласан. 1. Эрүүл мэндийн яамны ТЗУГ-ын 2024 оны 3/859 тоот албан бичгээр ирүүлсэн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг эхний хагас жилд хэрэгжүүлэн, тайланг хугацаанд нь хүргүүлсэн.	100%

						<p>2. Сүүлийн хагас жилд Эрүүл мэндийн яамны ТЗУГ-ын 2024 оны 3/2830 тоот албан бичгээр Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн ирүүлсэнтэй холбогдуулан, төвийн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.</p> <p>3. 2024 онд төвийн хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчил илрээгүй бөгөөд сонгон шалгаруулалт, санхүүгийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг ханган ажилласан.</p> <p>Мөн Авлигын эсрэг үйл ажиллагааны 5 бүлэг бүхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг 100 хувь биелүүлсэн.</p>	
6.10	ЗГҮАХ 2.1.7.5 Төвийн тусламж, үйлчилгээний нэгж өртгийг тооцно.	-	Өртөг тооцсон тусламж, үйлчилгэ эний тоо	Төвийн захирлын 2023 оны А/11 дүгээр “Төлбөртэй шинжилгээ үйлчилгээний жагсаалт батлах тухай” тушаалд заасан тарифаар хувийн аж ахуй нэгжүүдийн хүсэлтийн дагуу төлбөртэй шинжилгээг хийсэн.	Төлбөртэй шинжилгээ үйлчилгээн ий жагсаалты г шинэчлэн боловсруу лна.	<p>Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай” 49/А/118 хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтад заасан ажлыг хэрэгжүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгууллаа.</p> <p>1. Төвийн захирлын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/11 тушаалаар “Төлбөртэй шинжилгээ үйлчилгээний жагсаалтын тарифыг шинэчлэх”-ээр Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх, төлбөртэй тусламж, үйлчилгээний төрөл, орлого, хандив тусламжийг зарцуулах журмыг боловсруулах ажлын хүрээнд төвийн төлбөртэй хийгддэг шинжилгээний нэр төрлийн нэгж өртгийг тооцоолсон.</p> <p>2. Нийгмийн эрүүл мэндийн тандалтад суурилсан өвчний ангиллаар лабораторийн шинжилгээний тоог жилийн үйл ажиллагаагаар тооцоолж, мөн сорьц цуглуулалт, тээвэрлэлтийн тооцоог нэмж тооцооллоо. Нэмэлтээр Нэг иргэнд хийх шинжилгээний зардлыг тооцон төлбөртэй тусламж, үйлчилгээний зардалд нэмж тусгахаар тооцоог боловсруулсан.</p>	100%
<p>2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дараах бодлогын бичиг баримтуудад тусгагдсан өөрийн төвийн чиг үүрэгт хамааралтай арга хэмжээг тусгасан болно. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Алсын хараа-2050” 2. Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээ (ЗГҮАХ-Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр) 3. Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээ (МУТЖҮЧ-Монгол Улсын таван жилийн үндсэн чиглэл) 4. Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө 							

5. Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөө

2024 онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 48 арга хэмжээ төлөвлөсөн. Үүнд:

1. Шинээр төлөвлөсөн 12 ажил
2. 2023 оноос үргэлжлүүлэн хэрэгжүүлэх 10 ажил
3. Тогтмол зохион байгуулдаг 26 ажил багтсан байгаа болно.